# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

2018 он 05
сарын 11 өдөр

Дугаар 3Г-1/98

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

000545

МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар ХЭГ/986

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011


УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЦОЛМОН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх товыг тогтоож өгнө үү.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга Г.ЗАНДАНШАТАР

004480

Хавсралт 121 хуудастай

# МОНГОЛ УЛСЫН
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
# ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэлд:

“ХҮII.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
http://www.mojha.gov.mn

2018.05.09 № 1-1/2317

танай 2018.05.08-ны № 6-1/2676-т

САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР
ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Ц.НЯМДОРЖ

08 1645

DocCyaml5.2018

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74-68, http://www.mof.gov.mn

2018.05.08 № 6-1/2677
танай ______________-ны № ______________-т

САНГИЙН ЯАМАНД

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ:
САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ:
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

# ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

## Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах болсон дараахь эрх зүйн болон практик шаардлага байна. Үүнд:

### 1.1. Эрх зүйн үндэслэл, шаардлага

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 1.12-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" гэж, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 5 дугаар зүйлийн 5.2.2-т "Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож "Шилэн тендер шалгаруулалт" бодлого хэрэгжүүлнэ" гэж, мөн Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Ногоон хөгжлийн бодлого"-ын стратегийн 3 дахь зорилтод "Засгийн газрын худалдан авалтын 20-иос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад зарцуулах" гэж тус тус заасан.

### 1.2. Практик үндэслэл, шаардлага

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг 2005 онд баталж, 2006 оноос хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн бөгөөд өнгөрсөн 12 жилийн хугацаанд нийт 23 удаа нэмэлт, өөрчлөлт орж, Засгийн газрын худалдан авах ажиллагаанд тулгамдсан зарим тодорхой асуудлыг

зохицуулах арга хэмжээ авч иржээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр болон гадаад орон, олон улсын байгууллагын зээл тусламжийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний цар хэмжээ нэмэгдэж байгаатай холбогдуулан худалдан авах ажиллагааны өнөөгийн практик үйл ажиллагааг олон улсын шилдэг туршлага, зээл тусламж үзүүлж байгаа байгууллагуудын стандарт, шаардлагатай уялдуулах, худалдан авах ажиллагааг шуурхай, нийтэд нээлттэй, ил тод болгох, байгаль орчинд ээлтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг дэмжих, худалдан авах ажиллагааны зохицуулагдаагүй, ойлгомжгүй байгаа зарим асуудлыг тодорхой болгох, цахим тендер болон ногоон худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих төсөл, хөтөлбөрийн хүрээнд урьдчилсан худалдан авах ажиллагаа зохион байгуулах, тендерийн гомдол, маргааныг шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зэрэг хэрэгцээ, шаардлага үүсч байна.

Монгол Улсын Засгийн газар түншлэгч гадаад улс, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран 1990 оноос хойш хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр давхардсан тоогоор (нэг төсөл олон эх үүсвэрээс санхүүжсэн бол үүнийг оруулан тооцсон) 199 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн, заримыг нь одоо хэрэгжүүлсээр байна. Үүний дотор 2010-2017 онд нийт 74 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлснээс 14 төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг сунгасан байх бөгөөд үүний улмаас зөвхөн нэг төслийн хугацааг сунган хэрэгжүүлэхэд жилд ойролцоогоор 400.0 сая төгрөгийн урсгал зардал гарсан байна. Ийнхүү цаг хугацаа алдаж, хөрөнгө мөнгө нэмж зарцуулж байгаагийн нэг шалтгаан нь харьцангуй богино хугацаанд хэрэгжих боломжтой төсөл, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах худалдан авах ажиллагаа нь тухайн зээлийн гэрээг Улсын Их Хурлаар соёрхон батлагдах хүртэл цаг хугацаа алдаж, улмаар тухайн зээлээр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн зорилт хугацаандаа биелэгдэхгүй байх, ач холбогдол нь буурах сөрөг үр дагаврыг дагуулж байна. Иймд гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг урьдчилан зохион байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.

Засгийн газрын худалдан авах ажиллагааг ил тод, шилэн болгоход төрийн байгууллагуудын худалдан авах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэхээс гадна иргэд, хуулийн этгээдийн оролцоо, ойлголт чухал ач холбогдолтой юм. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуульд заасанчлан төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тендерийг цахим худалдан авалтын хэлбэрээр зохион байгуулж байгаа боловч уг хуульд "цахим тендер", "цахим тендерийн систем"-ийн талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүйгээс цахим худалдан авах ажиллагааг нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байна. Иймд цахим худалдан авах ажиллагаатай холбогдуулан ерөнхий гэрээний хүрээнд цахим дэлгүүрээс худалдан авах харилцааг боловсронгуй болгон хуульчлах шаардлагатай байна. Мөн цахимаар тендер зарлах, үр дүнг олон нийтэд мэдээлэх, хяналт тавих, цахим хэрэгслийг худалдан авах ажиллагаанд нэвтрүүлэх нь төрийн үйлчилгээг олон нийтэд ил тод, хүнд сурталгүй, шуурхай хүргэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Байгаль орчинд ээлтэй, ногоон худалдан авах ажиллагааг дэмжих, хөгжүүлэх зорилгоор тендерийн техникийн тодорхойлолтод тухайн бараа, ажил, үйлчилгээ нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх шалгуурыг оруулах нь дэлхий нийтийн хэрэгцээ шаардлагатай нийцэж, байгальд ээлтэй

ногоон бараа, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, дэмжих үндсэн зохицуулалт болно.

Сонгон шалгаруулалт явуулалгүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах нь сонирхлын зөрчил гарах, авлига, хээл хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах эрсдэл үүсгэхээс гадна төсвийн хөрөнгийг үрэлгэн, үр ашиггүй, үр нөлөөгүй зарцуулах, чанарын шаардлага хангахгүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, иргэд, хуулийн этгээдийг өрсөлдөх тэгш боломжоор хангахгүй, нэг буюу хэсэг бүлэг этгээдэд давуу байдал олгох үр дагавартай байдаг.

Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар /ШӨХТГ/-т тендерийн нээлт хийхээс өмнө хэдийд ч гомдол гаргах боломжтой байдлыг ашиглан тендер шалгаруулалтын үйл ажиллагааг санаатайгаар будлиантуулах, хугацаа хожих, үндэслэлгүй гомдол гаргаж төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааг хойшлуулахад хүргэж байна. Энэ нь тухайн худалдан авах ажиллагааны зорилго, чиглэлийг алдагдуулах, цаг хугацаа алдсанаар худалдан авах ажиллагааны чанар, үр дүнд сөрөг нөлөө үзүүлдэг. 2012-2017 оны байдлаар ШӨХТГ-т нийт 235 гомдлыг аж ахуйн нэгжүүдээс гаргасны 60-аас дээш хувь нь ямар нэг үндэслэлгүй гомдол гаргаж, тендерийн үйл ажиллагаанд хүндрэл учруулсаар байна.

Сүүлийн жилүүдэд Сангийн яаманд ирэх худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол, маргааны тоо тасралтгүй өсөн нэмэгдэж байна. 2016 оны тайлант хугацаанд нийт 3500 гаруй тендер зарлаж, үүнээс 606 тендерт гомдол ирсэн бол 2017 онд 5900 орчим тендер зарласны 813 тендерт тус тус гомдол иржээ. Энэ асуудлыг шийдэж байгаа гадаад орнуудын /нийт 20 гаруй улсын/ туршлагыг судлахад тендерийн гомдлыг шийдвэрлэхдээ тухайн тендерт санал болгосон үнийн дүнгийн хувиар тооцож барьцаа төлбөр, хураамж авдаг зохицуулалт үйлчилдэг байна. Гомдол, маргаан шийдвэрлэх үйл ажиллагаанд барьцаа төлбөр авах, гомдол нь үндэслэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд барьцаа төлбөрөө буцаан авах зохицуулалтыг бий болгосноор үндэслэлгүй гомдол гаргадаг байдал багасах, тендер шалгаруулалтыг түдгэлзүүлэх, удаашрах, цаг хугацаа алдах нөхцөлийг бууруулах ач холбогдолтой гэж үзэж байна.

Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх хуулийн өнөөгийн зохицуулалтыг илүү боловсронгуй, ойлгомжтой болгох үүднээс чанар, стандартын шаардлага хангасан дотоодын бараа, бүтээгдэхүүнд давуу эрх олгох зохицуулалтыг бий болгоно. Үүнтэй холбогдуулан дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой нөхцөлд гадаадын бараа нийлүүлэгчийг тендерт оролцуулахыг хориглосон өөрчлөлтийг тусгана. Мөн дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг үйлдвэрлэл эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар баталдаг байхаар хуулийн заалтыг өөрчилнө.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуульд худалдан авах ажиллагааны улсын байцаагчтай байхаар заасан боловч улсын байцаагчийн ажиллах дүрмийг хэн баталж, хэрхэн мөрдүүлэх талаар эрх зүйн ямар нэгэн зохицуулалт байхгүй байгааг тодорхой болгоно.

Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтыг зохион байгуулаад амжилтгүй болсон тохиолдолд хураангуй жагсаалтыг дахин гаргаж, санал ирүүлэх хугацааг ажлын 5 болон түүнээс дээш өдрөөр тогтоодог хэдий ч шууд гэрээ байгуулах талаар ямар нэгэн зохицуулалт байдаггүй. Үүнээс шалтгаалан зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтыг бүтэн жилийн турш зарлаж, улмаар төсөл, арга хэмжээ тухайн жилдээ хэрэгжих боломжгүй болдог. Иймд зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт 2 удаа амжилтгүй болсон нөхцөлд шууд гэрээ байгуулах заалт нэмнэ.

Худалдан авах ажиллагааг шуурхай болгох зорилгоор тендерийн хүчинтэй байх хугацааг 45-аас 30 хоног, шаардлагатай тохиолдолд 30 хоногоор сунгадаг зохицуулалтыг 10 хоногоор багасгаж, 20 хоног болгон өөрчилнө.

Худалдан авах ажиллагааг мэргэжлийн үндсэн дээр шуурхай зохион байгуулж, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх зорилгоор худалдан авах ажиллагааг хариуцсан бие даасан агентлаг байгуулах асуудлыг хуулийн төсөлд тусгана.

**Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасныг үндэслэн хуульд шинээр зүйл, хэсэг, заалт оруулах, өөрчлөх, хүчингүй болсонд тооцох зэргээр нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул уг хуулийн төслийг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дээр дурдсан практик хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн дараахь байдлаар тусгана:

1. Хуулийн агуулга, зорилго, нэгдмэл байдлыг хангах зорилгоор “өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ” гэх ойлголтыг зөвхөн тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах бараа, ажил, үйлчилгээ гэж тодорхойлно.

2. Олон улсын худалдан авах ажиллагааны шаардлага, зарчимд нийцүүлэн урьдчилсан худалдан авах ажиллагааны талаарх зохицуулалтыг нэмж тусгана.

3. Засгийн газрын худалдан авах ажиллагаа ил тод, шилэн байх зарчимд нийцүүлэн цахим худалдан авах ажиллагааны талаарх зохицуулалтыг нэмнэ. Үүнтэй холбогдуулан ерөнхий гэрээний хүрээнд цахим дэлгүүрээс худалдан авах харилцаа болон холбогдох бусад цахим худалдан авах ажиллагаатай холбоотой зохицуулалтуудыг хуульчилна.

4. Засгийн газрын тогтвортой, байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх сөрөг нөлөө, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг дэмжсэн зохицуулалтыг нэмж тусгана.

5. Худалдан авах ажиллагааны бодлого, зарчим болон төсвийн тухай хуульд нийцүүлэн зарим хэсэг, заалтыг хүчингүй болгоно.

6. Тендертэй холбоотой гардаг гомдол, маргааныг хариуцлагатай болгох үүднээс барьцаа төлбөр авах, түүнтэй холбогдох харилцааг зохицуулна.

7. Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, дотоодод үйлдвэрлэх бараа, бүтээгдэхүүний чанар стандартыг сайжруулах зорилгоор холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулна.

8. Худалдан авах ажиллагааны улсын хяналтын байцаагчийн эрх зүйн байдлыг тодорхой болгоно.

9. Төсөл, арга хэмжээг шуурхай, үр нөлөөтэй зохион байгуулахын тулд зөвлөх сонгон шалгаруулах тендер 2 удаа амжилтгүй болсон тохиолдолд гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх боломжийг бүрдүүлнэ.

10. Худалдан авах ажиллагааг хурдасгах зорилгоор тендер хүчинтэй байх хугацааг багасгах, мөн худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагыг дэмжих холбогдох нэмэлт, өөрчлөлтийг хийнэ.

11. Худалдан авах ажиллагааны практик шаардлагыг үндэслэн зарим нэр

томъёог шинээр тодорхойлно.

12. Монгол Улсын хууль тогтоомжийг шинэчлэх ажлын хүрээнд сүүлийн жилүүдэд олон салбарын хуулиуд шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төсөлд холбогдох салбарын худалдан авах ажиллагаатай холбоотой өөрчлөлтийг тусгана.

13. Хуулийн хэрэгжилтийг хангахад буруу ойлгодог, ойлголтын зөрүү бий болсноос маргаан дагуулдаг холбогдох хэсэг, заалтуудыг нэг мөр болгон томьёолж өөрчилнө.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар гарна:

-Засгийн газрын худалдан авах ажиллагааны төлөвлөлт боловсронгуй болж, худалдан авах ажиллагааг шуурхай, үр нөлөөтэй, ил тод байдлаар зохион байгуулж, төсөв хэмнэх боломж бүрдэнэ.

-Худалдан авах ажиллагааны цахим систем бүрдэж, олон нийтийн хяналт сайжирч, авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

-Худалдан авах ажиллагааны талаар төрөөс хэрэгжүүлэх бодлого, арга зүй, хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, худалдан авах ажиллагааг зохион байгуулах мэргэжлийн байгууллага болон орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааны бие даасан байдал хангагдана.

-Яам, агентлаг, төсвийн байгууллага, худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа тодорхой, уялдаатай болж, эрх үүргийн давхардал болон хуулийг хэрэглэх ойлголтын зөрүү арилна.

-Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, дотоодын бараа бүтээгдэхүүний чанар стандартад ахиц гарах, ногоон худалдан авалт хийх эрх зүйн орчин бүрдэж, ажлын байр шинээр бий болно.

Хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан улсын төсвөөс нэмэлт зардал гарахгүй.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байна.

Уг хуулийн төсөлтэй уялдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.

---oOo---

## ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,
ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг Улсын Их Хурлаас 2005 онд батлан 2006 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг хуульд өнөөдрийг хүртэлх хугацаанд нийт 23 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Дээрх хуулийг хэрэгжүүлэх явцад худалдан авах ажиллагаанд цахим системийг боловсронгуй болгох, үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах, авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчинд ээлтэй бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах, үндэсний үйлдвэрлэл, дотоодын бизнесийн орчныг төрөөс дэмжих, түүнчлэн олон улсын байгууллагуудад өргөн хэрэглэж байгаа урьдчилсан худалдан авах ажиллагааны тогтолцоог нэвтрүүлэх зэрэг асуудлуудыг хуульчлах практик шаардлага үүсч байна. Иймд худалдан авах ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дор дурдсан агуулгаар боловсруулсан болно:

1. Сүүлийн жилүүдэд гадаадын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас манай улсад олгож байгаа зээл, тусламж, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байна. Үүнтэй зэрэгцэн аливаа зээл, тусламж, хөрөнгө оруулалтын гэрээ, хэлэлцээрийг батлах болон худалдан авах үйл ажиллагааны онцлогоос хамааран олон улсын болон дотоодын хууль тогтоомжийн хүрээнд тодорхой цаг хугацаа шаардагддаг. Энэ нь тухайн зээл, тусламж, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх аливаа бүтээн байгуулалтын ажлууд удаашрах, үүнээс үүдэн тухайн төслийн ач холбогдол, үр өгөөж буурах, улмаар хэрэгжихгүй байх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна. Иймд энэхүү асуудлаас урьдчилан сэргийлэх, худалдан авах ажиллагааны шуурхай зохион байгуулалтыг хангах зорилгоор урьдчилан худалдан авах ажиллагааг хуулийн төсөлд шинээр нэмж тусгалаа.

2. Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, нээлттэй ил тод цахим засаглалыг бэхжүүлэн хөгжүүлэх, иргэд, олон нийтэд төрийн үйлчилгээг шуурхай, хүнд сурталгүй хүртээмжтэй хүргэх зорилгоор цахим худалдан авах ажиллагааны ойлголтыг тодорхой болгох, үйл ажиллагааг нь улам өргөжүүлэх үүднээс цахим худалдан авах ажиллагаатай холбоотой зохицуулалтыг дэлгэрэнгүй болгосон.

3. Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор “Ногоон хөгжлийн бодлого”-ын баримт бичгийг баталсан бөгөөд уг баримт бичгийн 3 дахь зорилтод “Засгийн газрын худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад зарцуулах” гэж тодорхойлсон. Иймд Улсын Их Хурлын энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, байгаль орчинд ээлтэй шинэ технологи нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй бизнесийг дэмжих зорилгоор ногоон худалдан авах ажиллагааг хуулийн төсөлд тодорхойлж, холбогдох

заалтыг нэмж тусгасан.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар аливаа худалдан авах ажиллагаанд оролцогчид Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар болон Сангийн яаманд тендертэй холбоотой гомдол гарган шийдвэрлүүлж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулах эрхтэй байдаг. Гэвч аж ахуйн нэгжүүдээс эрх ашгаа хамгаалахаас гадна бусдын ажилд садаа болох санаа зорилготойгоор үндэслэлгүй гомдол гаргах асуудал гарч, улмаар гомдлын тоо жилээс жилд эрс өсөх боллоо. Энэ нь ялангуяа улсын бүтээн байгуулалтын ажилд үлэмж хэмжээний хохирол учруулж, төлөвлөсөн ажлыг удаашруулах нөхцөлийг бий болгож байна. Иймд хуулийн төсөлд барьцаа төлбөр байршуулж гомдол гаргах, гомдол нь үндэслэлтэй бол барьцаа төлбөрийг буцаан олгох зохицуулалтыг нэмж тусгасан бөгөөд ингэснээр үндэслэлгүй гомдол гаргах явдал буурна гэж үзсэн болно.

5. Төрөөс татварын бус аргаар дотоодын үйлдвэрлэлийг дэмжих үндсэн нөхцөлүүдийн нэг нь Засгийн газрын худалдан авах ажиллагаа бөгөөд уг худалдан авалтаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлд давуу эрх олгох, дотоодод үйлдвэрлэх бараа, бүтээгдэхүүнийг өрсөлдүүлэх замаар чанар, стандартыг сайжруулах асуудал юм. Иймд дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хуулийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгож, зохих өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгасан.

6. Худалдан авах ажиллагааны практик шаардлагын улмаас урган гарч буй зарим зохицуулагдаагүй, маргаан дагуулдаг, ойлгомжгүй асуудлуудыг нэг мөр ойлгомжтой болгох зорилгоор хуулийн зарим хэсэг, заалтуудыг нэмэх, өөрчлөн найруулсан. Тухайлбал, худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах үүднээс тендерийн хүчинтэй байх хугацааг багасгасан.

Хуулийн төслийн талаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлэгт 21 аймгийн орон нутгийн өмчийн газрын мэргэжилтнүүд болон төрийн бус байгууллага, их дээд сургууль, судалгааны төв, олон улсын байгууллагын төлөөлөл оролцож саналаа өгсөн. Түүнчлэн хуулийн төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулан иргэдээс санал авсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2018 оны...дугаар сарын....-ны өдөр** **Улаанбаатар хот**

## ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсэг:**

“3.10.Засгийн газар олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авах, үнэт цаас арилжаалахтай холбоотой үйлчилгээ худалдан авахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.”

**2/5 дугаар зүйлийн 5.1.24-5.1.29 дэх заалт**:

“5.1.24.“өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ” гэж зөвхөн тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардагдах бараа, ажил, үйлчилгээг;

5.1.25."худалдан авах ажиллагааны цахим систем” гэж цахим програм хангамжийг ашиглан худалдан авах ажиллагааг төлөвлөх зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих цогц үйл ажиллагаа, мэдээллийн тогтолцоог;

5.1.26.“цахим худалдан авах ажиллагаа” гэж худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглан зохион байгуулах худалдан авах ажиллагааг;

5.1.27.“цахим дэлгүүр” гэж ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан худалдан авах ажиллагааны цахим системийн бүрэлдэхүүн хэсгийг;

5.1.28.“ногоон худалдан авах ажиллагаа” гэж эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг;

5.1.29.“урьдчилсан худалдан авах ажиллагаа” гэж улсын төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн гэрээг Улсын Их Хурал батлахаас

өмнөх шатанд тухайн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг урьдчилан зохион байгуулахыг."

**3/7 дугаар зүйлийн 7.4-7.6 дахь хэсэг:**

"7.4.Захиалагч гадаад улсын зээл, тусламж, олон улсын байгууллагын болон улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар сонгон шалгаруулж болно.

7.5.Энэ хуулийн 7.4-т заасан урьдчилсан худалдан авах ажиллагааны журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

7.6.Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална."

**4/8 дугаар зүйлийн 8.7.5, 8.13 дахь хэсэг:**

"8.7.5.энэ хуулийн $10^1$.1-д заасан дотоодын үйлдвэрээс авах боломжтой барааг импортын бараанаас тусад нь багцлах."

"8.13.Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно."

**5/29 дүгээр зүйлийн 29.6, 29.7 дахь хэсэг:**

"29.6.Урьдчилсан худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтад шалгарсан тендерт оролцогчтой тухайн зээл, тусламжийн олон улсын гэрээ, улсын төсвийн санхүүжилт батлагдаагүй тохиолдолд гэрээ байгуулахыг хориглоно.

29.7.Энэ хуулийн 29.4-т заасан тендерийн хүчинтэй байх хугацаа өнгөрснөөс хойш энэ хуулийн 29.6-д заасан зээл, тусламжийн олон улсын гэрээ, улсын төсвийн санхүүжилт батлагдсан тохиолдолд тухайн тендер шалгаруулалтыг хүчинтэйд тооцно."

**6/34 дүгээр зүйлийн 34.1.10 дахь заалт:**

"34.1.10.хүнсний аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагаар чанарын шаардлага хангасан тарианы үрийг үйлдвэрлэгчээс авах бол."

**7/36 дугаар зүйлийн 36.18 дахь хэсэг:**

"36.18.Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан зөвлөх сонгох тендер шалгаруулалт 2 удаа амжилтгүй болсон тохиолдолд шууд гэрээ байгуулж болно."

**8/$52^1$ дүгээр зүйлийн $52^1$.3 дахь хэсэг:**

"$52^1$.3.Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрмийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална."

**9/55 дугаар зүйлийн 55.5-55.7 дахь хэсэг**:

"55.5.Тендерт оролцогч нь энэ хуулийн 55.1-д заасан төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гомдол гаргахдаа барьцаа төлбөрийг төрийн сангийн холбогдох дансанд байршуулна.

55.6.Энэ хуулийн 55.5-д заасан барьцаа төлбөрийн хэмжээг тухайн тендер шалгаруулалтад оролцогчийн санал болгосон үнийн дүнгийн 1 хувиар тооцох бөгөөд тухайн барьцаа төлбөрийн дээд хэмжээ нь 20 сая төгрөгөөс хэтрэхгүй."

55.7.Тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ хуулийн 55.5-д заасан барьцаа төлбөрийг улсын орлого болгоно. Хэрэв гомдол үндэслэлтэй гэж шийдвэрлэгдсэн нөхцөлд барьцаа төлбөрийг буцаан олгоно."

**2 дугаар зүйл**.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21.1 дэх хэсгийн "өдөр тутмын сонин," гэсний дараа "худалдан авах ажиллагааны цахим систем болон" гэж, 22.4 дэх хэсгийн "хүлээлгэн өгснөөр" гэсний дараа "..., эсхүл худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлснээр" гэж, 55.1 дэх хэсгийн "нээлт хийхээс" гэсний дараа "ажлын 10-аас доошгүй хоногийн" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл**.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/5 дугаар зүйлийн 5.1.23 дахь заалт**:

"5.1.23."ерөнхий гэрээ" гэж захиалагч нь байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээг хоёр ба түүнээс дээш нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгчтэй 3 хүртэл жилийн хугацаанд үнэ болон бусад нөхцөлийг тохирч байгуулсан гэрээг."

**2/10$^1$ дүгээр зүйлийн 10$^1$.2 дахь хэсэг**:

"10$^1$.2.Энэ хуулийн 10$^1$.1-д заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг үйлдвэрлэл эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална."

**3/11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2 дахь заалт**:

"11.1.1.тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн болон тухайн бараа, ажил, үйлчилгээ нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлох;

"11.1.2.үндэсний стандарт, техникийн шаардлага, норм, норматив, дүрэм, зааварт үндэслэх, стандарт, техникийн норм байхгүй тохиолдолд Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын стандартад үндэслэх;"

**4/28 дугаар зүйлийн 28.7.3 дахь заалт**:

“28.7.3.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж, энэ зүйлд заасны дагуу үнэлэгдсэн тендерүүдийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж, “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендерийг сонгоно;”

**5/33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалт**:

“33.2.1.үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүр мэдээлэх;”

**6/45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг**:

“45.7.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, хил хамгаалах байгууллага, цагдаа, дотоодын цэрэг, хорих байгууллагын тусгай хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээг тухайн салбарын төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх, хорих байгууллагын өөрийн хэрэгцээний ажлыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгүүлэх нь үр ашигтай гэж захиалагч үзвэл төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авсан зөвшөөрлийн үндсэн дээр нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхгүй байж болно.”

**7/46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт**:

“46.1.6.гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;”

**8/52 дугаар зүйлийн 52.1.3, 52.1.7 дахь заалт**:

“52.1.3.худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгийн төсөл, цахим тендер шалгаруулах журам, цахим худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам, худалдан авах ажиллагаанд мэдээллийн технологи, цахим хэрэгслийг нэвтрүүлэх нөхцөл, журам батлах;”

“52.1.7.энэ хуульд заасны дагуу тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдол хянан шийдвэрлэх журам батлах;”

**4 дүгээр зүйл**.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.5 дахь заалт, 21.4 дэх хэсэг, 32.2 дахь хэсэг, 52.1.12 дахь заалт, 53.5.4 дэх заалтын “вэб” гэснийг “цахим” гэж, 10.1 дэх хэсгийн “эрх олгож болно.” гэснийг “эрх олгоно.” гэж, 10.1.7 дахь заалтын “50” гэснийг “30” гэж, $10^1$.1 дэх хэсгийн “шалгаруулахыг” гэснийг “оролцуулахыг” гэж, 24.5 дахь хэсгийн “45” гэснийг “30” гэж, 29.2 дахь хэсгийн “5-аас” гэснийг “6-аас” гэж, 29.4 дэх хэсгийн “30” гэснийг “20” гэж, 33.3 дахь хэсгийн “илгээсэн” гэснийг “зарласан” гэж, 34.1.1 дэх заалтын “33.4” гэснийг “36.18” гэж, 34.1.2 дахь заалтын “эрхийг” гэснийг “эрх, соёлын биет өвийг” гэж, 46.1.5 дахь заалтын “тухайн” гэснийг “энэ хуулийн 7.6-д зааснаас бусад” гэж, 45.4 дэх хэсэг, 48.4 дэх хэсэг, 53 дугаар зүйл, 53.1 дэх хэсэг, 53.5 дахь хэсэг, 53.7 дахь хэсгийн “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “Засгийн газрын худалдан авах ажиллагааны агентлаг” гэж, 45.5 дахь хэсэг, 53.3 дахь хэсэг, 53.4 дэх хэсэг, 53.5.2 дахь заалт, 53.5.6 дахь заалт, 53.6 дахь хэсгийн

“төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэснийг “Засгийн газрын худалдан авах ажиллагааны агентлагын” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл**.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.6 дахь хэсэг, 28.7.4 дэх заалт, 33.4 дэх хэсэг, 52.1.15 дахь заалт, 52.2 дахь хэсэг, 52.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

# ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ, ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

## 1. Шалгуур үзүүлэлт

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль нь улс орон, нийгэм эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх хуулиудын нэг бөгөөд Засгийн газрын худалдан авах ажиллагааг үр ашигтай, хэмнэлттэй, ил тод, өрсөлдөөнт, хариуцлагатай болгоход онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлахад худалдан авах ажиллагааг илүү боловсронгуй болгох, орчин үеийн худалдан авах ажиллагааны бодлого, зарчимтай нийцүүлэх шаардлагатай нь нотлогдсон тул энэхүү хуулийн төслийг боловсруулсан.

Энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлснээр дараах зэрэг үр дагавар гарах нь харагдаж байна. Үүнд:

- Урьдчилсан худалдан авах ажиллагааг урин дулааны улиралд хийгддэг зам, барилга, бүтээн байгуулалтын ажил, түүнчлэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг цаг хугацаанд нь амжилттай зохион байгуулах зорилгод ашигласнаар тухайн төсөл, арга хэмжээ цаг хугацаандаа амжилттай хэрэгжиж дуусах, нэмэлт урсгал зардал, санхүүжилт шаардагдахгүй байх бодит боломж гарч ирж байна.
- Цахим худалдан авах ажиллагааг явуулснаар төрийн байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн Засгийн газрын худалдан авах ажиллагаанд оролцох оролцоо болон өрсөлдөөн нэмэгдэх, төсөв хэмнэгдэх бодит үр дүн харагдаж байна. Үүнтэй уялдуулан цахим дэлгүүр болон ерөнхий гэрээгээр худалдаж авах худалдан авах ажиллагааны харилцааг зохицуулснаар Засгийн газрын худалдан авах ажиллагааны төсвийн хэмнэлттэй байх, түргэн шуурхай байх, ил тод байх зарчмууд бүрэн хангагдана.
- Ногоон худалдан авалтыг хэрэгжүүлснээр байгальд үзүүлэх хорт нөлөөг багасгах, шинэ бизнесийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох, дахин ашигласан материалаар хийсэн бүтээгдэхүүний зах зээл, ногоон бүтээгдэхүүний тоо, үйлдвэрлэл нэмэгдэж байгаль орчинд нөлөөлж буй үйлдвэрлэл, бүтээгдэхүүний тоо багасан, өнөөдөр тулгамдаад буй усны, эрчим хүчний, хог хаягдлын асуудлууд багасах зэрэг эерэг үр дүн ирээдүйд бий болох ач холбогдол харагдаж байна.
- Улсын төсвийн санхүүжилтээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад сонирхлын зөрчил үүсэх, авлига, хээл хахууль өгөх авах, албан тушаалаа урвуулан ашиглах нөхцлөөс урьдчилан сэргийлэх, иргэд, хуулийн этгээдийн ижил тэгш, хүртээмжтэй өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор одоогийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 (Монгол Улсын Хөгжлийн банкны үйл

ажиллагаа) болон түүнтэй холбогдох хэсгүүдийг хүчингүй болгох юм. Ингэснээр худалдан авах ажиллагааны өрсөлдөөн, ил тод байдалд эерэг үр дагавар гарна гэж дүгнэсэн.

- Тендер шалгаруулалтын явцад тендерт оролцогчид хугацаа хожих зорилгоор тендерийн нээлт болохоос өмнө богино хугацаанд (зарим тохиолдолд цөөн минутын өмнө) гомдол гаргадаг. Үүнийг хязгаарласнаар худалдан авах ажиллагаа цаг хугацаандаа үр дүнтэй явагдах боломж бүрдэнэ.
- Худалдан авах ажиллагааны явцад аливаа гомдол гарах нь зүйн хэрэг ч сүүлийн жилүүдэд тендер шалгаруулалтыг санаатайгаар удаашруулах, өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор гомдол, маргаан гаргах байдал нэмэгдсэн. Энэ нь тухайн тендерээр хэрэгжих төсөл, арга хэмжээ удаашрах, чанаргүй хийгдэх, үргүй зардал гарах нөхцөл байдлыг үүсгэдэг. Тухайлбал, 2016 оны тайлант хугацаанд нийт 3500 гаруй тендер зарлаж үүнээс 606 тендерт гомдол ирсэн бол 2017 онд 5900 орчим тендер зарласны 813 тендерт тус тус гомдол ирсэн байна. Иймд үндэслэлгүй гомдлыг хязгаарлаж төрийн байгууллагуудын нөөц, цаг хугацааг хэмнэх, аливаа тендерээр хэрэгжих төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзлээ.
- Дотоодын тендерт оролцогчдод давуу эрх олгох, дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах ажиллагааг дэмжихийн тулд дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой барааг импортын бараанаас тусад нь багцалж тендер зарлах, түүнчлэн дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан Засгийн газраар батлуулж мөрдүүлэх нь үр дүнтэй. Ингэснээр дотооддоо үйлдвэрлэн нийлүүлэх бараа бүтээгдэхүүн нэмэгдэх, дотоодын аж ахуйн нэгжүүдийн бизнесийн орлого нэмэгдэнэ гэж үзэж байна.
- Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн бүрэн эрхийг ойлгомжтой болгож зохицуулснаар худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх, гомдол маргааныг шийдвэрлэхэд ахиц гарах бол зөвлөх сонгох тендер шалгаруулалт 2 удаа амжилтгүй болсон нөхцөлд гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх нь тухайн худалдан авах ажиллагааны зорилго бүрэн биелэх, цаг хугацаа алдахгүй байх бодит боломжийг бий болгоно.
- Харьцуулах үнэ гэсэн тодорхойлолтыг ойлгомжтой болгох үүднээс тендерийн шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан тендерүүдийн үнийн саналуудыг харьцуулах үнэ гэх ба эдгээрээс хамгийн бага үнэтэй тендерийг сонгож гэрээ байгуулах тухай ойлголтыг тодорхой болгосон. Ингэснээр тендерийн техникийн шаардлага хангасан тендерүүдийн үнийн саналуудыг харьцуулж хамгийн бага үнэтэй тендерийг сонгохыг “хамгийн бага харьцуулах үнэтэй” тендер хэмээн нэрлэх ойлголтыг илүү ойлгомжтой тодорхой болгох юм.
- Одоогийн мөрдөж буй хуулийн “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэсэн нэрийг “Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага” болгон

өөрчлөх нь хуулийг цаашид нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд эерэг үр дагавар авчирна гэж үзсэн.

- Одоогийн хуулийн гэрээ шууд байгуулах зохицуулалтад соёлын биет өвийг хамгаалах, мөн түүнчлэн хүнсний аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагаар стандартын шаардлага хангасан тарианы үрийг худалдан авах боломжийг оруулав. Ингэснээр зөвхөн 1 этгээдийн өмчлөлтэй, 1 этгээдтэй байгуулах боломжтой соёлын биет өвийг хамгаалах боломж бий болно. Мөн хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай тарианы үрийг шууд үйлдвэрлэгчээс худалдан авах нь чанарт болоод төсвийн хэмнэлтэд чухал ач холбогдолтой байна.
- Улс орны эдийн засгийг хөгжүүлэхэд туслах чухал арга хэмжээнүүдийн нэг нь Засгийн газрын үнэт цаас гаргаж гадаад зах зээлд арилжаалах, мөн олон улсын банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авах зэрэг асуудалд зөвлөх үйлчилгээ худалдан авах шаардлага үүсдэг. Олон улсын зах зээлийн нөхцөл байдал тэр дундаа бонд хувьцааны зах зээл, хүү, үнэ нь цаг, минутаар хэмжигдэн хурдацтай өөрчлөгдөж байдаг тул тааламжтай нөхцөл байдалд Засгийн газрын үнэт цааасыг олон улсын зах зээлд яаралтай арилжаалах, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авах зэрэг асуудалд зөвлөх үйлчилгээг шуурхай сонгон шалгаруулах шаардлага үүсдэг. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар үйлчилгээ авахдаа зарлах, шалгаруулах, сонгоход цаг хугацаа хэт их алддаг тул хуулинд өөрчлөлт орсоноор олон улсад нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн зөвлөх үйлчилгээг авах боломжийг Засгийн газарт бий болгох чухал ач холбогдолтой байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах нөхцөл, бололцоог дэмжих зорилгоор одоогийн хуулийн 10.1.7-д заасан “50 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн эзэлдэг аж ахуйн нэгж” гэснийг “30 ба түүнээс дээш” гэж багасгах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тодорхой эерэг үр дагавар бий болгоход түлхэц өгнө гэж үзсэн.
- Худалдан авах ажиллагааг түргэн шуурхай болгох нь тендерт оролцогч аж ахуйн нэгж төдийгүй худалдан авах ажиллагааны үр шимийг хүртэгчид болон Засгийн газарт чухал ач холбогдолтой юм. Энэ үүднээс тендерийн хүчинтэй байх хугацааг 45-аас 30 хоног, мөн 30 хоног хүртэл сунгадаг зохицуулалтыг 20 хоног болгон өөрчлөх нь тендерийг түргэн шуурхай, хариуцлагатай зохион байгуулахад эрсдэлгүй гэж дүгнэсэн.
- Сүүлийн жилүүдэд олон салбарын хуулиуд шинэчлэн батлагдсан, мөн одоогийн хуульд байгаа тодорхой бус, алдаатай, шаардлагагүй зарим заалт, нэр томъёоны найруулгыг засч, өөрчилснөөр худалдан авах ажиллагааны зохицуулалтууд илүү ойлгомжтой, хэрэглэхэд хялбар болох юм.

Хуулийн төслийн үр нөлөөг дээр дурдсан асуудлуудын хүрээнд даraах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэллээ. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
3. Зардал
4. Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

## 2. Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ

### 2.1. Зорилгод хүрэх байдал

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 5.1.23-29, 7, 8, 10, 10$^{1}$, 11, 21, 22, 24, 28, 29, 33, 34, 36, 45, 46, 48, 52, 52$^{1}$, 53, 55.1-р зүйлийн холбогдох хэсэг, заалтуудыг судалж үзсэн болно.

Хуулийн төсөл нь гадаадын зээлдэгч улс, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас манай улсад олгож байгаа зээл, тусламжийг үр ашигтай зарцуулах зорилгоор урьдчилсан худалдан авах ажиллагааг бий болгох, иргэд, олон нийтийн дунд худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөөнт, төрийн шуурхай, хүртээмжтэй байдлыг бий болгох үүднээс цахим тендерийн үйл ажиллагааг нэвтрүүлэх, Засгийн газрын тогтвортой, байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй ногоон худалдан авах ажиллагааны бодлого, зорилгыг хэрэгжүүлэх, худалдан авах ажиллагааны үндэслэлгүй гомдол маргааныг хязгаарлах, тэдгээрийг оновчтой шийдвэрлэх, Монгол Улсын дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа, бүтээгдэхүүнийг дэмжих болон хуулийг ойлгомжтой тодорхой болгох үндсэн зорилтуудыг дэвшүүлэн энэхүү хуулийн төслийг боловсруулсан.

Дэвшүүлж буй зорилтуудыг тодорхойлох, түүний хэрэгцээ шаардлагыг тодруулах зорилгоор дараах уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Үүнд:

1. Хуулийн төслийн үндсэн шаардлага, практикт тулгамдаж буй асуудлууд болон хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлох зорилгоор Сангийн сайдын тушаалаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүний дунд “2 өдрийн эрчимжүүлсэн” сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар урьдчилсан, ногоон, цахим, гомдол маргааны шийдвэрлэлт, дотоодоос худалдан авах бараа, бүтээгдэхүүний зохицуулалтыг боловсронгуй болгох болон худалдан авах ажиллагааны өнөөгийн шийдвэрлэвэл зохих бусад асуудлуудыг практикт хэрхэн нэвтрүүлэх талаарх холбогдох танилцуулга, хэлэлцүүлгийг явуулж, саналуудыг авч тусгасан.
2. Монгол Улсын 21 аймгийн орон нутгийн өмчийн харилцааны газруудын хэмжээнд иргэд, олон нийтийн хэлэлцүүлгийг улс, орон даяар хэрхэн зохион байгуулах талаар хуулийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулах арга зүйн удирдамжаар хангасан.
3. Яамдын хэмжээнд хуулийн төслийн тандан судалгаа, үзэл баримтлал, хуулийн төслийн зохицуулах асуудлуудын талаар хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан. Яамдын худалдан авах ажиллагааг хариуцсан нийт 16 мэргэжилтэн, ажилтнууд хэлэлцүүлэгт оролцож, тус тусын яамдын зохицуулах асуудал, шалтгаануудын талаар холбогдох санал, тайлбар өгснийг судалж, нэгтгэж

хуулийн төсөлд тусгасан.

4. Монгол Улсын өмнөх Засгийн газрын яамдын саналыг авч хуулийн төсөлд тусгасан ба 2017 оны 09-р сард Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан уг хуулийн төсөлд 2018 оны 03-р сард дахин санал авч нэгтгэн хуулийн төслийн ажлын хэсгээр нэгтгэн дүгнэсэн.
5. Иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудын хэмжээнд мөн хуулийн төслийн судалгаа, үзэл баримтлал, хуулийн зохицуулалтын талаарх сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, холбогдох санал дүгнэлтүүдийг тусгаж ажилласан.
6. Урьдчилсан худалдан авалт, цахим худалдан авах ажиллагаа, гомдол маргаан шийдвэрлэх, дотоодын худалдан авалтыг дэмжих болон холбогдох бусад худалдан авах ажиллагааны асуудлаар Индонез, Филиппин, Австри улсуудад туршлага судлах гадаад аялалыг Азийн хөгжлийн банкны техник туслалцааны хүрээнд зохион байгуулсан. Аялалаар тухайн улсуудын урьдчилсан, цахим худалдан авах ажиллагааны зохицуулалт, гомдол маргааны шиидвэрлэлт, үр дүн, ач холбогдлын талаар ойлголт авснаар Монгол Улсад хэрхэн үр дүнтэй ашиглаж болох харьцуулсан дүгнэлт судалгааг хийж хуулийн төсөлд уялдуулан оруулж тусгав.
7. Улс орон даяар явуулсан олон нийтийн судалгаа, саналыг нэгтгэх ажлыг гүйцэтгэж, тайланг аймаг тус бүрээр гаргасан. Олон нийтийн судалгаа, санал асуулгын хэлэлцүүлэгт улсын хэмжээнд нийт 830 гаруй иргэд, 180 гаруй аж ахуйн нэгж хамрагдсанаас 96 хувь нь санал өгсөн бөгөөд зарчмын хувьд хуулийн төслийг нийт оролцогчдын 71 орчим хувь нь дэмжсэн.
8. Хуулийн төслийг Монгол Улсын Сангийн яамны цахим хуудас, www.tender.gov.mn цахим хуудсуудад байрлуулж, нийт сонирхсон иргэд, аж ахуйн нэгжээс санал авсан.
9. Байгаль орчинд ээлтэй, ногоон худалдан авах ажиллагааг дэмжих зорилгоор НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл нь Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтарсан Техникийн зөвлөлдөх уулзалтыг яамд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгуулж тогтвортой ногоон худалдан авах ажиллагааны онол, арга зүй, практикийн асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлж холбогдох саналыг тусгаж ажилласан.
10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн асуудлыг худалдан авах ажиллагаатай холбогдуулан дэмжих, үүнтэй уялдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөлтэй уулзаж хуулийн төсөлд ямар зарчмын зохицуулалтууд байх талаар уулзалтыг зохион байгуулсан.

Дээрх уулзалт, хэлэлцүүлгүүдийн үеэр урьдчилсан, ногоон, цахим, гомдол маргааныг шийдвэрлэх зохицуулалт, дотоодын худалдан авах ажиллагааг дэмжих болон бусад худалдан авах ажиллагааны асуудлуудыг хуульчлан зохицуулснаар нийгэм, эдийн засгийн амьдралд бодит үр дүн гарна гэдгийг хэлэлцүүлэгт оролцогчид

онцлон дурдаж байв.

Тухайлбал урьдчилсан худалдан авах ажиллагааг нэвтрүүлснээр төсөл, хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны цаг хугацааг багасгаж, төслийн зорилго,үр дүнг амжилттай дуусгах, зардлын менежментийг сайжруулах үндсэн нөхцөл болно. Үр дүнд орон нутаг, Засгийн газар, иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд эерэг нөлөөлөл үзүүлнэ гэдэгт оролцогчид санал нэгтэй байв.

Засгийн газрын тогтвортой, байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн худалдан авах ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй гэдэгт хэлэлцүүлэгт оролцогчид мөн адил санал нэгтэй байв.

Цахим худалдан авах ажиллагааг бий болгож жигдрүүлснээр улс орны хэмжээнд худалдан авах ажиллагаанд оролцогчдын оролцоо, өрсөлдөх боломж нэмэгдэх, худалдан авах ажиллагаа ил тод, үр өгөөжтэй байх зарчмыг улам бэхжүүлнэ гэдэгт хэлэлцүүлэгт оролцогчид хүлээн зөвшөөрч байв.

Гомдол маргааны шийдвэрлэлтийг боловсронгуй болгох, үндэслэлгүй гомдлыг хязгаарлах, тендер шалгаруулалтад үндэслэлгүй гомдол гаргах байдал багасах, буруутай албан тушаалтан, аж ахуйн нэгжид холбогдох арга хэмжээ авах бололцоо бүрдэнэ.

Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах зохицуулалтыг сайжруулснаар худалдан авах ажиллагаанд оролцогчдын өрсөлдөөн нэмэгдэж, дотоодын аж ахуйн нэгжийн ажлын байр, орлого нэмэгдэх, улмаар дотоодын бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэх боломж бий болно гэж үзсэн.

Хэрэв хуулийн төслөөр зохицуулахгүй, одоогийн байгаа хуулийн зохицуулалтыг хэвээр үлдээснээр дараах сөрөг үр дагавар гарах эрсдэлтэй байна. Үүнд:

Одоогийн хуулийн зохицуулалтаар гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд урьдчилсан худалдан авах ажиллагааг ашиглах бололцоогүй ба энэ хэвээрээ байснаар төсөл, хөтөлбөрийн худалдан авах ажиллагаа хугацаа алддаг, засгийн газарт нэмэлт зардал гардаг, ард түмэнд чиглэсэн төсөл, хөтөлбөрийн зорилго алдагдах нөхцөл байдал үргэлжлэх эрсдэлтэй юм.

Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлого”-ын стратегийн 3.3.6-д “Засгийн газрын худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад зарцуулах” гэж заасан зорилт биелэгдэхгүй байх, Монгол Улсын байгаль орчныг хамгаалах, байгальд ээлтэй худалдан авах ажиллагааг хөхиүлэн дэмжих, Монгол Улсын Засгийн газар Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд сөрөг нөлөө үзүүлэх бодит байдал бий болсон.

Цахим худалдан авах ажиллагааг хуульчлахгүй байснаар одоогийн хуулийн зохицуулалтын цахим үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах нөхцөл бүрэлдэхгүй байх, хуулийн хэрэгжилтийг нэг мөр ханган биелүүлэх зохицуулалт дутагдах, тендерт

оролцогч иргэд, аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадвар, хүртээмжийг хангаж чадахгүй байх, сонирхлын зөрчлүүд бий болох нөхцөл зэргүүд тус тус бүрэлдэж байгаа нь хуулийн төслийг боловсруулах зайлшгүй шаардлагатай байгааг харуулсан.

Хуулийн үйлчлэлд хамаарагдахгүйгээр сонгон шалгаруулалтгүй тендерийн үйл ажиллагааг явуулах нь үр ашиггүй бөгөөд төрийн худалдан авах ажиллагааны шударга, нээлттэй байх зарчимд нийцэхгүй байгаа. Мөн тендерт оролцогч хүссэн цагтаа гомдол гаргах нь тендерийг будлиантуулах, тендерийг үр ашиггүй болгох нөхцөлүүдийн нэг болдог.

Улсын байцаагчийн эрх үүргийг ойлгомжтой болгохгүй байснаар гомдол, маргаан, хяналт шалгалтын ажлын чанарт сөрөг нөлөө үзүүлдэг бол зөвлөх үйлчилгээнд шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэхгүй байснаар зөвлөх үйлчилгээний гэрээ удаан хугацаанд зарлагддаг, тухайн ажлын ач холбогдол буурах үр дагаварыг үүсгэж байдаг.

Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах зохицуулалт энэ хэвээрээ байвал дотоодын бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэхгүй байх, дотоодын барааны стандарт боловсруулалт хөгжихгүй байх улмаар тендер шалгаруулалтанд оролцох дотоодын аж ахуйн нэгжийн тоо өсөхгүй байх зэрэг сөрөг үр дагавартай.

Хуульд байгаа тодорхой бус, алдаатай, шаардлагагүй заалт, нэр томъёог санаатай болон санамсаргүйгээр буруу ойлгож ашиглах, хуулийн зохицуулалтуудыг өөрийн нөхцөл байдалд тааруулан өөр өөр байдлаар ашиглах, худалдан авах ажиллагаанд оролцогч бүх талууд нийтээрээ нэг ойлголтоор хуулийг хэрэглэхгүй байх нөхцлүүд арилахгүй үргэлжлэх эрсдэлтэй юм.

Хуулийн төслийн зорилгод хүрэх байдлыг шинжлэн харьцуулж үзэхэд дараах зэрэг үр дагавар харагдаж байна.

1. Урьдчилсан худалдан авах ажиллагааг хэрэгжүүлснээр Засгийн газрын төсөл, хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт боловсронгуй болж, худалдан авах ажиллагаа богино хугацаанд шуурхай, үр дүнтэй явагдах, төсөв хэмнэх боломж бүрдэнэ.

2.Цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлж жигдрүүлснээр худалдан авах ажиллагааны өрсөлдөх чанарт илт ахиц гарах, ил тод байдлыг бэхжүүлэх, гомдол маргаан гарахгүй байх нөхцөл буурах зэрэг ахиц гарна.

3. Яам, агентлаг, төсвийн байгууллага, худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа тодорхой болж, эрх үүргийн давхардал болон хуулийг хэрэглэх ойлголтын зөрүү арилна.

4.Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, дотоодын бараа бүтээгдэхүүний чанар стандартад ахиц гарах, ногоон худалдан авалт хийх эрх зүйн орчин бүрэлдэн хөгжих, ажлын байр шинээр бий болох зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлнэ.

5. Худалдан авах ажиллагааг удирдан зохион байгуулах төрийн захиргааны байгууллага, худалдан авах ажиллагаанд хяналт тавих төрийн захиргааны төв байгууллага болон орон нутаг дахь худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааны бие даасан байдал хангагдах зэрэг ач холбогдолтой байна.

## 2.2. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Хуулийн төслийг баталж хэрэгжүүлснээр Монгол Улсын Засгийн газар, гадаадын зээл, тусламж олгогч улс, олон улсын банк, санхүүгийн байгууллага, яамд, засгийн газрын агентлагууд болон иргэд, аж ахуйн нэгжийн худалдан авах ажиллагаанд бодит эерэг өөрчлөлт, эдийн засгийн үр ашигтай нөхцөл бий болох нь хуулийн төслийн тандан судалгаа, олон нийтийн хэлэлцүүлгийн явцад харагдсан.

Тухайлбал яамд, агентлаг, 21 аймгийн хэмжээнд нэгтгэсэн дүнгээр нийт 850 хүн, 180 орчим аж ахуйн нэгж хуулийн төслийн санал асуулга, хэлэлцүүлэгт оролцсоны 71 орчим хувь нь хуулийн төслийн агуулга, үзэл санаа, ач холбогдлыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн байгаа нь хуулийн төслийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг харуулсан.

Мөн түүнчлэн олон улс, бүс нутгийн хөгжлийг дэмжих, ядуурлыг бууруулах зорилготой Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Азийн дэд бүтцийн хөгжлийн банк, Америк тив хоорондын хөгжлийн банк зэрэг байгууллагуудаас урьдчилсан, цахим, дотоодын бараа бүтээгдэхүүнд давуу эрх олгох, ногоон худалдан авах ажиллагааг хөхиүлэн дэмжиж ашиглахыг уриалж зөвлөдөг. Энэ нь хуулийн төслийн агуулга, зохицуулалт зөв бөгөөд олон улсын практик шаардлагад нийцсэн алхам гэдгийг харуулж байна.

## 2.3. Зардал

Хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдийн тендерийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох зардал тодорхой түвшинд гарах боловч энэ нь одоогийн төсвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл байхгүй. Холбогдох зардлын талаар тайлбарлавал:

Хуулийн төслийн 7.4-т *"Захиалагч гадаад улсын зээл, тусламж, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар сонгон шалгаруулж болно"* гэж заасан. Уг заалтын хүрээнд тендерт шалгарсан тендерт оролцогчтой гэрээ байгуулахгүй ба гагцхүү зээл, тусламжийн гэрээ хэлэлцээр эцэслэн батлагдсан нөхцөлд гэрээ байгуулах эрх үүсэх талаар тендерт оролцогчид мэдэгдэнэ. Урьдчилсан худалдан авах ажиллагааны харилцаа нь тендерт оролцогч болон захиалагч талуудын хооронд аливаа гэрээний болон санхүүжилтийн эрх, үүрэг үүсгэхгүй.

Тендерийн баримт бичгийг бэлдэхтэй холбоотой бэлтгэл ажлын зардал одоогийн төсвийн хүрээнд шийдэгдэх бөгөөд нэмэлт зардал гарах нөлөөлөл байхгүй байна.

Төслийн баримт бичгийг бэлдэх, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, холбогдох техник, эдийн засгийн судалгаа хийх зэрэг арга хэмжээг авахад худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, инженер, төслийн зохицуулагч гэсэн ажилтнуудыг нэн тэргүүнд авч ажиллуулах тохиолдолд холбогдох цалин, урамшууллыг одоогийн байгаа төсвийн дотоод зохицуулалтаар шийдвэрлэнэ. Харин зээл, тусламжийн гэрээ, хэлцэл батлагдаж хүчин төгөлдөр болмогч холбогдон гарсан зардлыг гадаад зээл, тусламж үзүүлэгч байгууллагаас нөхөн санхүүжилтээр эргэж авах

зарчмаар ажиллах юм.

Ногоон худалдан авах ажиллагааны тухайд хуулийг хэрэгжүүлэх хүрээнд иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт зардал үүсгэхгүй, харин төрийн байгууллагын хувьд ачаалал нэмэгдүүлэхээр байна. Гэвч энэхүү ачаалал нь худалдан авах ажиллагааны явцад шударга бус өрсөлдөөн болон хүний эрх зөрчигдөхөөс хамгаалахад чиглэгдэнэ. Ингэхдээ асуудал хариуцсан төрийн байгууллагын чиг үүрэгт нэмэлт, өөрчлөлт бий болгохгүй, харин үйл явцыг илүү тодорхой, ил тод болгоно.

Энэхүү хуулийн төслөөр зохицуулагдаж байгаа худалдан авах ажиллагааны бусад асуудлууд болох хүчингүй болох заалтууд, тендерийн нээлттэй холбоотой цаг хугацааны асуудал, улсын байцаагчийн бүрэн эрхийн зохицуулалт, зөвлөх үйлчилгээнд шууд гэрээ байгуулах боломж, дотоодын худалдан авалтыг дэмжих заалт, гомдол маргааны шийдвэрлэлт болон бусад холбогдох асуудлуудад төсвийн зардал нэмэгдэх аливаа нөлөөлөл байхгүй болно.

Цахим худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах хүснэгтээр харуулсан зардлын тооцоолол гарч байгаа боловч уг зардлыг төсөвт нөлөөлөл үзүүлэхгүйгээр одоо байгаа батлагдсан орон тоо, төсөв болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны журмаар шийдвэрлэнэ.

| № | Зардлын нэр, төрөл | Зарцуулах хугацаа (Хүн/сар) | | | | Зардал /төгрөгөөр/ | Үүрэг |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Багадаа | Дундаж | Ихдээ | Тооцоолж буй | | |
| **1** | **Одоогийн нөхцөл байдлын судалгаа хийх -Asls** | | | | | | |
| 1.1 | Хууль эрх зүйн судалгаа | *0.2* | *0.1* | *0.5* | *0.18* | 396,000 | Бизнес аналист, системийн шинжээч |
| 1.2 | Бизнесийн орчны судалгаа | *0.2* | *0.1* | *0.5* | *0.18* | 396,000 | Бизнес аналист, системийн шинжээч |
| 1.3 | Технологийн судалгаа | *0.2* | *0.1* | *0.5* | *0.18* | 396,000 | Бизнес аналист, системийн шинжээч |
| 1.4 | Өгөгдлийн судалгаа | *0.2* | *0.1* | *0.5* | *0.18* | 396,000 | Бизнес аналист, системийн шинжээч |
| 1.5 | Програм хангамжийн судалгаа | *0.2* | *0.1* | *0.5* | *0.18* | 396,000 | Бизнес аналист, системийн шинжээч |
| 1.6 | Төслийн төлөвлөлт | *0.2* | *0.1* | *0.5* | *0.18* | 396,000 | Бизнес аналист, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | системийн шинжээч |
| 1.7 | Эрсдлийн удирдлага | *0.2* | *0.1* | *0.5* | *0.18* | 396,000 | Бизнес аналист, системийн шинжээч |
| | | **1.4** | **0.7** | **3.5** | **1.26** | **2,772,000** | |
| **2** | **Байх ёстой загварыг боловсруулах-ToBe (Хуулийн өөрчлөлттэй холбогдуулан гарах өөрчлөлт)** | | | | | | |
| 2.1 | Бизнесийн архитектур | *0.2* | *0.1* | *0.5* | *0.18* | 396,000 | Бизнес аналист, системийн шинжээч |
| 2.2 | Өгөгдлийн архитектур | *0.2* | *0.1* | *0.5* | *0.18* | 396,000 | Бизнес аналист, системийн шинжээч |
| 2.3 | Технологийн архитектур | *0.2* | *0.1* | *0.5* | *0.18* | 396,000 | Бизнес аналист, системийн шинжээч |
| | | **0.6** | **0.3** | **1.5** | **0.54** | **1,188,000** | |
| **3** | **Суурь кодчилол (Хуулийн өөрчлөлттэй холбогдуулан гарах кодын өөрчлөлт)** | | | | | | |
| 3.1 | Өгөгдлийн сангийн кодчлол | *0.5* | *1* | *1.5* | *1* | 2,000,000 | Хөгжүүлэгч |
| 3.2 | Системийн суурь кодчлол | *2* | *3* | *4* | *3* | 4,200,000 | Хөгжүүлэгч |
| | | **2.5** | **4** | **5.5** | **4** | **6,200,000** | |
| **4** | **Тестчлэл, IT Audit** | | | | | | |
| 4.1 | Модуль тестчлэл | *0.2* | *0.1* | *0.5* | *0.183333* | 256,667 | Тестер |
| 4.2 | Үйл ажиллагааны (performance) тестчлэл | *0.2* | *0.1* | *0.5* | *0.183333* | 366,667 | Хөгжүүлэгч |
| 4.3 | IT Аудит | *0.2* | *0.1* | *0.5* | *0.183333* | 458,333 | IT Auditor |
| 4.3 | Нууцлал аюулгүй байдлын тестчлэл | *0.2* | *0.1* | *0.5* | *0.183333* | 366,667 | Хөгжүүлэгч |
| | | **0.8** | **0.4** | **2** | **0.7333333** | **1,448,333** | |
| **5** | **Суурьлуулалт (Deployment)** | | | | | | |
| 5.1 | Hardware-ийн суурьлуулалт | *0.5* | *1* | *1.5* | *1* | 2,000,000 | Систем админ |
| 5.2 | Software-ийн суурьлуулалт | *0.5* | *1* | *1.5* | *1* | 2,000,000 | Систем админ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | **1** | **2** | **3** | **2** | **4,000,000** | |
| **6** | **Сургалт** | | | | | | |
| 6.1 | Системийн хэрэглэгчийн сургалт | *1* | *1.5* | *2* | *1.5* | 3,300,000 | Төслийн менежер |
| 6.2 | Системийн админы сургалт | *1* | *1.5* | *2* | *1.5* | 3,300,000 | Төслийн менежер |
| 6.3 | Систем хөгжүүлэлтийн сургалт | *1* | *2* | *3* | *2* | 4,400,000 | Төслийн менежер |
| | | **3** | **5** | **7** | **5** | **11,000,000** | |
| **8** | **Support** | | | | | | |
| 8.1 | Support үйлчилгээ | *5* | *10* | *15* | *10* | **22,000,000** | ТӨБЗГ |
| | **НИЙТ:** | **14.3** | **22.4** | **37.5** | **23.533333** | **48,608,333** | |

***Тооцолж буй өдөр = (max + min + 4*avg)/6***

**БУСАД ЗАРДАЛ (Тоног төхөөрөмжийн өргөтгөл, гарын авлага, сургалт семинар)**

| **№** | **Зардлын нэр, төрөл** | **Тоо хэмжээ** | **Нэгж үнэ** | **Нийт үнэ** |
|---|---|---|---|---|
| 1 | Сервер компьютер | 4 | 15,500,000 | 62,000,000 |
| 2 | Сторайж | 1 | 30,000,000 | 30,000,000 |
| 3 | Холболтын төхөөрөмж (Switch L2, L3 San, Cabel networking) | N/A | 20,000,000 | 20,000,000 |
| 5 | Системийн гарын авлага хэвлүүлэх | 1 | 15,000,000 | 15,000,000 |
| 6 | Workshop зохион байгуулах | 2 | 7,500,000 | 15,000,000 |
| | | | Нийт: | **142,000,000** |

**НИЙТ ТООЦООЛОГДСОН ЗАРДАЛ**

| | | |
|---|---|---|
| 1 | Програм хангамжийн боловсруулах, хөгжүүлэх зардал болон холбогдох зардалууд | **48,608,333** |
| 2 | Сервер тоног төхөөрөмж, болон холбогдох бусад зардалууд | **142,000,000** |
| | **Нийт:** | **190,608,333** |

### 2.4. Хуулийн төслийн уялдаа холбоо

| | |
|---|---|
| 1.Хуулийн төслийн зохицуулалт тухайн | Хуулийн зорилт нь Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, гомдол гаргаж |

| | |
|---|---|
| хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх; | шийдвэрлүүлэх, тэрчлэн худалдан авах ажиллагааг ил тод, үр ашигтай, өрсөлдөх тэгш боломжтой, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд тулгуурлан явуулахад чиглэдэг.<br>Хуулийн төслийн зохицуулалт нь уг хуулийн зорилттой бүрэн нийцэж байгаа. |
| 2.Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх; | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд хамааралтай зарим зохицуулалтуудыг хуульчилсан. Шинэ зохицуулалтуудыг хуульчилснаар худалдан авах ажиллагааны нэр болон Монгол Улсын Үндсэн Хууль болон бусад хуулийн нэр, тэдгээрийн харилцаанд сөрөг нөлөөлөл байхгүй. |
| 3.Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх; | Хуулийн төсөлд шинээр тодорхойлсон нэр томьёо нь тухайн хуулийн төслийн зохицуулалтуудыг илүү ойлгомжтой болгосон байх бөгөөд бусад хуулийн нэр томьёотой давхцал байхгүй, бүрэн нийцэж байна. |
| 4.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх; | Хуулийн төсөлд Монгол Улсын Үндсэн Хууль болон бусад холбогдох хуулийн зүйл заалттай зөрчилдөх агуулгатай зүйл, заалт тусгагдаагүй болно. |
| 5.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх; | Хуулийн төслийн зүйл, заалтууд одоогийн хуулийн зүйл заалттай давхардсан агуулгатай зүйл, заалт тусгагдаагүй болно. |
| 6.Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх; | Хуулийн төслөөр хуулийн зохицуулалтуудыг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой заасан. Тухайлбал төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон орон нутагт засаг даргын хэрэгжүүлэх чиг, үүргийг тодорхой заасан. |
| 7.Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх; | Хуулийн төсөлд одоогийн нийгэм, эдийн засаг, хөгжлийн явцтай уялдуулан зайлшгүй зохицуулах шаардлагатай асуудлуудыг хуулийн төсөлд тусгасан. Орхигдуулсан болон ойлгомжгүй болгосон аливаа зохицуулалт байхгүй. |
| 8.Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх; | Хуулийн төсөлд давхардал үүсгэх, шинэ чиг үүргүүдийг давхардуулан тусгасан зүйл үгүй. |

| | |
|---|---|
| 9. Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх; | Хуулийн төсөлд төрийн байгууллагын чиг үүргүүдийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх зохицуулалт байхгүй болно. |
| 10.Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх; | Хуулийн төсөлд ямар нэгэн албан татвар, төлбөр, хураамжтай холбоотой зохицуулалт агуулагдаагүй болно. |
| 11. Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх; | Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусаагүй болно. |
| 12. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх; | Монгол Улсын Үндсэн Хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан агуулга бүхий зохицуулалт уг хуулийн зүйл, заалтад тусгагдаагүй болно. |
| 13. Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх; | Хуулийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг зөрчих ямар нэгэн зохицуулалт тусгагдаагүй. |
| 14. Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгох, өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн ямар нэгэн зохицуулалт тусгагдаагүй. |
| 15. Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх; | Хуулийн төсөлд аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулаагүй болно. |
| 16. Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын | Хуулийн төсөлд тусгагдсан хэм хэмжээг зөрчигчид хүлээлгэх хариуцлага Монгол Улсын Зөрчлийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуульд заасны дагуу шийдэгдэнэ. |

| | |
|---|---|
| талаар тодорхой тусгасан эсэх. | |
| | |

### 3. Зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь улс орны хэмжээнд худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөөнт байдлыг дэмжиж, үр ашигтай, хариуцлагатай байх нөхцөлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хуулийн зохицуулалтуудыг тодорхой тусгаж, холбогдох нэмэлт, өөрчлөлтийг хийж боловсруулсан байна.

Хуулийн төслийн үр нөлөө, холбогдох зардлын тооцоог “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд хуулийн төсөл нь хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

________o0o________

# ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН[1]

*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэх асуудал*

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг 2005 онд баталж, 2006 оноос хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн өнгөрсөн 12 жилийн хугацаанд 23 удаа нэмэлт, өөрчлөлт орж, Засгийн газрын худалдан авах ажиллагаанд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн олон арга хэмжээг хуульчлан хэрэгжүүлсэн.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны цар хүрээ өргөжиж, гадаадын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас олгож байгаа зээл, санхүүжилт, буцалтгүй тусламж нэмэгдэж байгаатай холбогдуулан олон улсын худалдан авах ажиллагааны шаардлага, зарчимд тендерийн үйл ажиллагааг уялдуулан нийцүүлж урьдчилсан худалдан авах ажиллагаа, иргэд, олон нийтийн дунд худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөөнт, төрийн шуурхай, хүртээмжтэй байдлыг бий болгох үүднээс цахим тендерийн үйл ажиллагааг нэвтрүүлэх, Засгийн газрын тогтвортой, байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн худалдан авах ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх, худалдан авах үйл ажиллагааны зарим зохицуулагдаагүй, ойлгомжгүй байгаа асуудлуудыг нэг мөр ойлгомжтой болгох үүднээс хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах практик хэрэгцээ, шаардлагууд үүсээд байна.

1. Азийн Хөгжлийн Банк /АХБ/-ны техник туслалцааны хөтөлбөрийн тайланд дурдсанаар зээл, буцалтгүй тусламжийн цар хүрээ өсөхийн зэрэгцээ Засгийн газраас хэрэгжүүлж байгаа төслүүдийг үр дүнтэй, төлөвлөсөн цаг хугацаанд багтааж, чанартай удирдах арга барилыг шаардаж байгааг дурдсан.

АХБ болон бусад олон улсын байгууллагуудын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа ихэнх төсөл төлөвлөсөн хугацаанаасаа хоцорч явдаг. Энэ нь төслүүдийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд шууд сөргөөр нөлөөлдөг. Жишээ нь 1991 оноос АХБ-ны санхүүжилтийн зээлээр хэрэгжиж хаагдсан 28 төслийн 26 нь хугацаандаа хэрэгжиж дуусаагүй байх бөгөөд дунджаар хугацаа нь 2 жил сунгагдсан байна.[2]

Монгол Улсын Засгийн газар, түншлэгч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран 1990 оноос хойш хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр

---

[1] Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу боловсруулав.
[2] Техникийн туслалцааны тайлан: II Үндсэн асуудал.

давхардсан тоогоор /нэг төсөл олон эх үүсвэрээс санхүүжсэн бол үүнийг оруулан тооцсон/ 199 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байна. Үүнээс 2010-2017 оны хугацаанд нийт 74 төсөл, арга хэмжээ хэрэгжсэнээс 14 төсөл, хөтөлбөр сунгагдсан бөгөөд 1 төсөл, арга хэмжээ сунгагдсанаар жилд ойролцоогоор төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нийт 400.0 сая төгрөгийн урсгал зардал гардаг байна. Мөн хугацаа сунгагдсанаар тухайн төсөл, хөтөлбөрийн үндсэн зорилго, чиглэл алдагдах, үр ашиггүй байдал үүсэх эрсдэлийг дагуулж байна.

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд зээл, тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн худалдан авах ажиллагааг зээл, тусламжийн гэрээг Улсын Их Хурлаар соёрхон батлахаас өмнөх шатанд эхлүүлснээр хугацаа алдах, түүний улмаас үргүй зардал гардаг байдлыг багасгах юм.

Иймд Улсын Их Хурлаар зээл, тусламжийн гэрээг соёрхон батлахаас өмнөх шатанд урьдчилсан худалдан авах ажиллагааг явуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага үүссэн.

2. Засгийн газрын худалдан авах ажиллагааг ил тод, шилэн болгоход төрийн байгууллагууд бүрэн цахим хэлбэрт шилжихээс гадна иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоо, ойлголт маш чухал. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулиар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тендерийг цахим худалдан авалтын хэлбэрээр зохион байгуулж байгаа боловч хуульд “цахим тендер”, “цахим тендерийн систем”-ийн талаарх тодорхой зохицуулалтууд байхгүйгээс цахим худалдан авах ажиллагааг нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа тул цахим худалдан авах ажиллагааны талаарх зохицуулалт практик шаардлагаар урган гарч ирж байна.

Цахим худалдан авах ажиллагааг зохицуулсан харилцаа хууль тогтоомжид байхгүйгээс захиалагч байгууллагууд цахим хэлбэрээр тендер шалгаруулалт зарлах, мэдээллийг түргэн шуурхай цаг хугацаанд нь олон нийтэд мэдээлэхгүй уламжлалт буюу цаасан хэлбэрээр зохион байгуулах ашиг сонирхол ихтэй байгаа нь Засгийн газрын шилэн тендерийн бодлого, худалдан авах ажиллагааны ил тод байдал, үр ашгийг алдагдуулах эрсдэлтэй байна.

Монгол Улсын Засгийн газраас худалдан авах ажиллагааны үйл явцыг шуурхай, олон нийтэд хүртээлтэй, ил тод зохион байгуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах үүднээс худалдан авах ажиллагааны цахим тогтолцоог бий болгох зорилтыг тавин ажиллаж байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5 дугаар зүйлийн 5.2.2-т “Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлнэ” гэж тусгасан.

3. Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Ногоон хөгжлийн бодлого"-ын стратегийн 3 дахь зорилтод "Засгийн газрын худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад зарцуулах" гэж заасан ба мөн бодлогын 4.2-т Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтээр Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувь байхаар тогтоож өгсөн.

Засгийн газрын тогтвортой, байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн худалдан авах ажиллагааны эрх зүйн орчин бүрдээгүйгээс дээрх зорилтод хүрэх боломжгүй сөрөг үр дагавар үүсээд байна.

Ногоон худалдан авалтыг хэрэгжүүлсэнээр байгальд үзүүлэх хорт нөлөөг багасгах, шинэ бизнесийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох, дотоодын нийт бүтээгдэхүүнийг өсгөхөөс гадна дахин ашигласан материалаар хийсэн бүтээгдэхүүний зах зээл, ногоон бүтээгдэхүүний тоо, үйлдвэрлэл нэмэгдэж байгаль орчинд нөлөөлж буй үйлдвэрлэл, бүтээгдэхүүний тоо багасан, өнөөдөр тулгамдаад буй усны, эрчим хүчний, хог хаягдлын асуудлууд багасах зэрэг сайн талтай тул ногоон худалдан авах ажиллагааны талаарх зохицуулалт практик шаардлагаар мөн гарч ирж байна.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6-д "Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж, мөн хуулийн 3.8-д "Ирээдүйн өв сан, Ирээдүйн өв сан корпорацийн үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж тус тус заасан.

Сонгон шалгаруулалтгүйгээр улсын төсвийн санхүүжилтээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах нь сонирхлын зөрчил, авлига, хээл, хахууль, албан тушаалаа урвуулан ашиглах орчинг бий болгохоос гадна бараа, ажил, үйлчилгээг эдийн засгийн үр ашиггүй зарцуулах, чанарын шаардлага хангахгүй ажил, бараа, үйлчилгээг дэмжих, иргэд, хуулийн этгээдийн ижил тэгш, хүртээмжтэй өрсөлдөх боломжийг хязгаарлах, нэг болон хэсэг бүлэг этгээдэд давуу байдал олгох боломжийг бүрдүүлсэн байгаа нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, зарчимд нийцэхгүй байна. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6, 3.8 дахь заалтуудыг хүчингүй болгох шаардлага үүсээд байна.

Мөн төсөл, арга хэмжээг цаг алдалгүй шуурхай, амжилттай зохион байгуулахын тулд зөвлөх сонгох тендер шалгаруулалт 2 удаа амжилтгүй болсон нөхцөлд гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх боломжийг, мөн орон нутагт хэрэгжих төсөл, арга хэмжээний хувьд тухайн шатны Засаг дарга нь захиалагч байхаар,

тендерт оролцогчдоос тендер шалгаруулалтын үйл ажиллагааг санаатайгаар будлиантуулах, цаг хугацаа хожих зэрэг зорилгоор тендерийн нээлт хийхээс хэдхэн цагийн өмнө гомдол гаргадаг байдлыг таслан зогсоохоор холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулахаас гадна худалдан авах үйл ажиллагааны практик шаардлагын улмаас ойлгомжгүй байгаа асуудлуудыг нэг мөр ойлгомжтой болгох үүднээс зарим нэр томъёог өөрчилж, хуульд байгаа зарим нэг шаардлагагүй, ойлгомжгүй үг, найруулгыг хасах нь зүйтэй байна.

## УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.12-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” гэж, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.2.2-т “Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлнэ” гэж, мөн Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлого”-ын 3.3.6-д “Засгийн газрын худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад зарцуулах” гэсэн зорилтыг тусгаж, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэхээр төлөвлөн, хэрэгжүүлэх үүргийг Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүлээлгэсэн байна.[3]

Мөн хуульд тусгагдсан шинэлэг зохицуулалтуудыг хэрэгжүүлэхийн тулд урьдчилсан, цахим, ногоон худалдан авах ажиллагааны үндэслэл, журам, заавар, аргачлалыг хуулиар шинэчлэн тогтоох шаардлагатай байна.

Урьдчилсан, цахим, ногоон худалдан авах ажиллагаа болон бусад асуудалд дүн шинжилгээ хийж, хувилбаруудыг сонгож тандан судалсны үндсэн дээр Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын[4] /цаашид Аргачлал гэх/-ын 5.5-т заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хувилбарыг сонгож байна.

Иймд урьдчилан тандан судлах ажиллагааг гүйцэтгэхдээ Аргачлалын 2.1-д заасан дараах дарааллын дагуу хийж гүйцэтгэлээ:

1. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох;

---

[3]Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралт
[4]Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

2. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулан судлах;

3. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;

4. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан судлах;

5. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;

6. Зөвлөмж боловсруулах.

## АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Засгийн газрын худалдан авах ажиллагааны цар хүрээ өргөжиж, гадаадын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас олгож байгаа зээл, санхүүжилт, буцалтгүй тусламж нэмэгдэж байгаатай холбогдуулан олон улсын худалдан авах ажиллагааны шаардлага, зарчимд тендерийн үйл ажиллагааг уялдуулан нийцүүлж урьдчилсан худалдан авах ажиллагаа, иргэд, олон нийтийн дунд худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөөнт, төрийн шуурхай, хүртээмжтэй байдлыг бий болгох үүднээс цахим тендерийн үйл ажиллагааг нэвтрүүлэх, Засгийн газрын тогтвортой, байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн худалдан авах ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх, худалдан авах үйл ажиллагааны зарим зохицуулагдаагүй, ойлгомжгүй байгаа асуудлуудыг нэг мөр ойлгомжтой болгох үүднээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах нэг үндэслэл болсон болно.

Монгол Улсын Засгийн газар, түншлэгч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран 1990 оноос хойш хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр давхардсан тоогоор /нэг төсөл олон эх үүсвэрээс санхүүжсэн бол үүнийг оруулан тооцсон/ 199 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байна. Үүнээс 2010-2017 оны хугацаанд нийт 74 төсөл, арга хэмжээ хэрэгжсэнээс 14 төсөл, хөтөлбөр сунгагдсан бөгөөд 1 төсөл, арга хэмжээ сунгагдсанаар жилд ойролцоогоор төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нийт 400.0 сая төгрөгийн урсгал зардал гардаг байна. Мөн хугацаа сунгагдсанаар тухайн төсөл, хөтөлбөрийн үндсэн зорилго, чиглэл алдагдах, үр ашиггүй байдал үүсэх эрсдэлийг дагуулж байна. */Урьдчилсан худалдан авах ажиллагааны процесс, зураглал болон олон улсын банк, санхүүгийн байгууллагын зарчмыг Хавсралт 1, 2-оос тус тус харна уу/*

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулиар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тендерийг цахим худалдан авалтын хэлбэрээр зохион байгуулж байгаа боловч хуульд “цахим тендер”, “цахим тендерийн систем”-ийн талаарх тодорхой

зохицуулалтууд байхгүйгээс цахим худалдан авах ажиллагааг нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа.

Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Ногоон хөгжлийн бодлого"-ын стратегийн 3 дахь зорилтод "Засгийн газрын худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад зарцуулах" гэж заасан ба мөн бодогын 4.2-т Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтээр Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувь байхаар тогтоож өгсөн. Засгийн газрын тогтвортой, байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн худалдан авах ажиллагааны эрх зүйн орчин бүрдээгүйгээс дээрх зорилтод хүрэх боломжгүй сөрөг үр дагавар үүсээд байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6-д "Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж, мөн хуулийн 3.8-д "Ирээдүйн өв сан, Ирээдүйн өв сан корпорацийн үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж тус тус заасан. Сонгон шалгаруулалтгүйгээр улсын төсвийн санхүүжилтээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах нь сонирхлын зөрчил, авлига, хээл, хахууль, албан тушаалаа урвуулан ашиглах орчинг бий болгохоос гадна бараа, ажил, үйлчилгээг эдийн засгийн үр ашиггүй зарцуулах, чанарын шаардлага хангахгүй ажил, бараа, үйлчилгээг дэмжих, иргэд, хуулийн этгээдийн ижил тэгш, хүртээмжтэй өрсөлдөх боломжийг хязгаарлах, нэг болон хэсэг бүлэг этгээдэд давуу байдал олгох боломжийг бүрдүүлсэн байгаа нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, зарчимд нийцэхгүй байна.

Тухайлбал Монгол Улсын Хөгжлийн банк нь 2016 оны байдлаар 355 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2 их наяд, 28 тэрбум 781 сая 900 мянган төгрөгийг зарцуулахдаа тендерийн сонгон шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТХ-иас гадуур өөрсдийн эрх хэмжээний хүрээнд явуулж байгаа нь төрийн худалдан авах ажиллагааны бодлого, зарчимтай нийцэхгүй байх ба ашиг сонирхол, авлига хээл хахуулийг бий болгох, мөн улсын төсвийн санхүүжилтийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчмыг алдагдуулж байгаа өндөр эрсдэлийг бий болгосон байна.

Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүд Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар /ШӨХТГ/-т тендерийн нээлт хийхээс өмнө хэдийд ч гомдол гаргах боломжтой байдлыг ашиглан тендер шалгаруулалтын үйл ажиллагааг санаатайгаар будлиантуулах, цаг хугацаа хожих, үндэслэлгүй гомдол гаргаж төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааг хойшлуулахад хүргэдэг. Энэ нь тухайн худалдан авах ажиллагааны зорилго, чиглэлийг алдагдуулах, цаг хугацаа алдсанаар худалдан авах ажиллагааны чанар, үр дүнд сөрөг нөлөө үзүүлдэг.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн 52[1] дүгээр зүйлийн дагуу худалдан авах ажиллагааны улсын байцаагчтай байхаар заасан бөгөөд түүний бүрэн эрхийг мөн зааж өгсөн. Гэтэл улсын байцаагчийн ажиллах дүрмийг хэн баталж, хэрхэн мөрдүүлэх талаар эрх зүйн ямар нэгэн зохицуулалт байхгүйн улмаас улсын байцаагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдал үүсээд байна.

Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтыг зохион байгуулаад амжилтгүй болсон тохиолдолд хураангуй жагсаалтыг дахин гаргаж, санал ирүүлэх хугацааг ажлын 5 ба түүнээс дээш өдрөөр тогтоохоор заасан байдаг боловч шууд гэрээ байгуулах талаар ямар нэгэн зохицуулалт байдаггүй болно. Үүнээс шалтгаалан зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтыг жилийн турш зарладаг нөхцөл байдал үүсээд байна. Тухайлбал мэргэжлийн байгууллага зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтыг жилийн турш зарласан бөгөөд үүнээс шалтгаалан уг төсөл арга хэмжээ тухайн жилд хэрэгжих боломжгүй нөхцөл үүсдэг байна.

Сүүлийн жилүүдэд захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулахаас зайлсхийж батлагдсан төсөвт өртгийг хувааж тендер шалгаруулалтын онцгой журмын дагуу төлөвлөн зохион байгуулдаг байдал нэмэгдэж байна. Тухайлбал сүүлийн 3 жилийн улсын хэмжээний нээлттэй тендер шалгаруулалтын хувь хэмжээ огцом буурч байна. Энэ нь худалдан авах ажиллагааны ил тод, хэмнэлттэй, үр ашигтай, өрсөлдөх боломжтой, шударга байх үндсэн зарчим ихээхэн алдагдаж байгааг харуулж байна.

Иймд дээрх шаардлагуудыг харгалзан асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна.

***Зорилт:***

- Олон улсын банк, санхүүгийн байгууллага болон бусад гадаад орнуудын зээл, тусламжийн хүрээнд явуулах төслийн худалдан авах ажиллагаанд урьдчилсан худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх механизмыг тогтоох;

- Цахим худалдан авах ажиллагааг бий болгох, хэрэгжүүлэх үндэслэл журмыг тогтоох;

- Байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний шалгуур үзүүлэлтийн худалдан авах ажиллагааны баримтлах аргачлалыг тогтоох;

- Худалдан авах үйл ажиллагааны зарим зохицуулагдаагүй, ойлгомжгүй байгаа асуудлуудыг нэг мөр ойлгомжтой болгох.

***Хуулийн төсөл батлагдаж хэрэгжсэнээр:***

- Засгийн газрын худалдан авах ажиллагааг төлөвлөх ажиллагаа боловсронгуй болж, худалдан авах ажиллагаа богино хугацаанд шуурхай, үр дүнтэй, ил тод байдлаар зохион байгуулагдаж, төсөв хэмнэх боломж бүрдэнэ.

- Худалдан авах ажиллагааг удирдан зохион байгуулах төрийн захиргааны байгууллага, худалдан авах ажиллагаанд хяналт тавих төрийн захиргааны төв байгууллага болон орон нутаг дахь худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааны бие даасан байдал хангагдана.

- Яам, агентлаг, төсвийн байгууллага, худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа тодорхой болж, эрх үүргийн давхардал болон хуулийг хэрэглэх ойлголтын зөрүү арилна.

- Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төрийн бодлогоор дэмжих, ногоон худалдан авалт хийгдэх эрх зүйн орчин бүрдэж, байгальд үзүүлэх хорт нөлөөг багасгах, ажлын байр шинээр бий болгох, дотоодын нийт бүтээгдэхүүнийг өсгөхөөс гадна дахин ашигласан материалаар хийсэн бүтээгдэхүүний зах зээл, ногоон бүтээгдэхүүний тоо, үйлдвэрлэл нэмэгдэж байгаль орчинд нөлөөлж буй үйлдвэрлэл, бүтээгдэхүүний тоо багасан, өнөөдөр тулгамдаад буй усны, эрчим хүчний, хог хаягдлын асуудлууд багасах юм.

- Худалдан авах ажиллагааны ил тод, хэмнэлттэй, үр ашигтай, өрсөлдөх боломжтой, шударга байх үндсэн зарчим хангагдана.

## АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж, дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт

| Хувилбар | | Зорилгод хүрэх байдал | Зардал, үр өгөөжийн харьцаа | Үр дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Тэг хувилбар | Зорилгод хүрэх боломжгүй. | Хамааралгүй. | Үр дүн сөрөг |
| 2 | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх | Зорилгод хүрэх боломжгүй. | Хамааралгүй. | Үр дүн сөрөг |
| 3 | Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх | Зорилгод хүрэх боломжгүй. | Хамааралгүй. | Үр дүн сөрөг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Төрөөс санхүүгийн интервенци хийх | Зорилгод хүрэх боломжгүй. | Хамааралгүй. | Үр дүн сөрөг |
| 5 | Захиргааны шийдвэр гаргах | Зорилгод хүрэх боломжгүй. | Хамааралгүй. | Үр дүн сөрөг |
| 6 | Хууль тогтоомжийн төсөл боловсруулах | - Олон улсын банк, санхүүгийн байгууллагын зарчим, үзэл баримтлалд нийцүүлж урьдчилсан худалдан авах ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлсэнээр,<br>- Цахим худалдан авах ажиллагааны талаарх эрх зүйн зохицуулалтыг сайжруулснаар,<br>- Засгийн газрын тогтвортой, байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн худалдан авах ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлсэнээр зорилгодоо хүрэх боломжтой. | Иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт зардал үүсгэхгүй, харин төрийн байгууллагын хувьд ачаалал нэмэгдүүлэхээр байна. асуудал хариуцсан төрийн байгууллагын чиг үүрэгт нэмэлт, өөрчлөлт бий болгохгүй, харин үйл явцыг илүү тодорхой, ил тод болгоно. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ. | Үр дүнтэй |

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар олон нийт, төрийн бус байгууллагуудыг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенци хийх, захиргааны шийдвэр гаргаснаар дээрх асуудлуудыг шийдвэрлэж дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Олон улсын банк, санхүүгийн байгууллагын санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд нь гол төлөв улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх чухал зорилго тавьсан байдаг. Төсөл, арга хэмжээг амжилттай явуулах гол нөхцөл нь төслийн худалдан авах ажиллагааг зөв бөгөөд амжилттай эхлүүлэх явдал бөгөөд ингэснээрээ төслийг төлөвлөгдсөн цаг хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олгодог. Нөгөө талаас энэ нь Засгийн газарт нэмэлт зардал гарах, аливаа хүндрэл бэрхшээл үүсгэх эрсдэлийг бууруулдаг. */Урьдчилсан худалдан авах ажиллагааны зардлын тооцооллын хүснэгт, дүгнэлтийг Хавсралт 3-аас үзнэ үү/*

Тендер шалгаруулалттай холбоотой мэдээ мэдээлэл илүү боловсронгүй, цаг хугацаандаа мэдээлэгдэх боломж бүрдэж мэдээллийн ил тод байдал сайжирна. Мөн олон нийтийн хяналт сайжирч, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх боломж дээшлэнэ. Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоо сайжрах юм.

Ногоон хөгжлийн бодлогын стратегийн 3 дахь зорилтод[5] "Засгийн газрын худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад зарцуулах" гэж, мөн бодлогын

[5]Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт

4.2-т заасан Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтээр Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувь байхаар тогтоосон зорилтод хүрэхийн тулд ногоон худалдан авах ажиллагааны зохицуулалт зайлшгүй шаардлагатай.

Нөгөө талаас Засгийн газрын тогтвортой, байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн худалдан авах ажиллагааг хэрэгжүүлсэнээр байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төрийн бодлогоор дэмжих, ногоон худалдан авалт хийгдэх эрх зүйн орчин бүрдэж, байгальд үзүүлэх хорт нөлөөг багасгах, ажлын байр шинээр бий болгох, дотоодын нийт бүтээгдэхүүнийг өсгөхөөс гадна дахин ашигласан материалаар хийсэн бүтээгдэхүүний зах зээл, ногоон бүтээгдэхүүний тоо, үйлдвэрлэл нэмэгдэж байгаль орчинд нөлөөлж буй үйлдвэрлэл, бүтээгдэхүүний тоо багасан, өнөөдөр тулгамдаад буй усны, эрчим хүчний, хог хаягдлын асуудлууд багасах зэрэг эерэг үр дагавар бий болж, хуулийн хэрэгжилт бодитой хангагдах нөхцөл бүрдэх юм.

Иймхүү хууль тогтоомжийн төсөл боловсруулснаар урьдчилсан, цахим, ногоон худалдан авах ажиллагааны шинэ зохицуулалтыг бий болгохоос гадна худалдан авах үйл ажиллагааны зарим зохицуулагдаагүй, ойлгомжгүй байгаа асуудлуудыг нэг мөр ойлгомжтой болгох асуудлыг шийдвэрлэж дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжтой нь харагдаж байна.

## ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Зохицуулалтын үр нөлөөг Аргачлалын 6.2-т заасан ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

*Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 4-аас үзнэ үү.*

### *Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө*

Урьдчилсан, цахим, ногоон худалдан авах ажиллагаа нь хүний эрхийг хууль бусаар хязгаарлах, ялгаварлан гадуурхах зэрэг хүний эрхийн зөрчлийг агуулаагүй гэж дүгнэж байна. Харин хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа ба хүний эрхийг хамгаалах нийгэм, эдийн засгийн арга хэмжээнд эерэг нөлөө үзүүлнэ.

### *Эдийн засагт үзүүлэх үр нөлөө*

Урьдчилсан, цахим, ногоон худалдан авах ажиллагааны аль аль нь иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт зардал үүсгэхгүй, харин төрийн байгууллагын хувьд ачаалал нэмэгдүүлэхээр байна.

Гэвч энэхүү ачаалал нь худалдан авах ажиллагааны явцад шударга бус өрсөлдөөн болон хүний эрх зөрчигдөхөөс хамгаалахад чиглэгдэж байна.

Иймд дээрх зохицуулалтууд нь асуудал хариуцсан төрийн байгууллагын чиг үүрэгт нэмэлт, өөрчлөлт бий болгохгүй, харин үйл явцыг илүү тодорхой, ил тод болгоно.

***Нийгэмд үзүүлэх үр нөлөө***

Урьдчилсан, цахим, ногоон худалдан авах ажиллагааны аль аль нь нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэгээр нөлөөлөхөөс гадна өнөөдөр тулгамдаад байгаа олон асуудлыг шийдвэрлэх, илүү үр дүнг бий болгоно. Тухайлбал, ажил эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлд эерэг нөлөө үзүүлнэ.

***Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө***

Урьдчилсан, цахим, ногоон худалдан авах ажиллагаа нь агаар, зам тээвэр, эрчим хүч, ан амьтан ургамлыг хамгаалах, усны нөөц, хөрсний бохирдол, газар ашиглалт, нөхөн сэргээгдэх байгалийн баялагийн ашиглалтын үйл ажиллагаанд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин байгаль орчныг хамгаалахтай холбоотой багц хуулийн хэрэгжилтийг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

***Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх***

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тусгасан байна. [6]

Урьдчилсан, цахим, ногоон худалдан авах ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, үзэл санаанд харшилсан, зөрчсөн зохицуулалт байхгүй. */Үндсэн хууль бусад хуультай нийцэж буй талаарх хүснэгтийг Хавсралт 5-аас харна уу/*

Олон улсын гэрээний тухай хуулиар зээлийн тухайн олон улсын гэрээ Улсын Их Хурлаар соёрхон батлагдсаны дараа хүчин төгөлдөр үйлчилж эхлэдэг зарчимтай. Урьдчилсан худалдан авах ажиллагаа нь Олон улсын гэрээний тухай хуулийн энэхүү зарчимтай зөрчилдөх зохицуулалтыг бий болгохгүй байх нь дараах байдлаар тодорхойлогдоно:

Олон улсын зээлийн гэрээний нөхцөлд худалдан авах ажиллагааг урьдчилан эхлүүлж явуулж болох талаарх заалтыг гэрээний талууд тохирч болдог. Урьдчилсан худалдан авах ажиллагааг явуулсан нөхцөлд энэ нь зээлийн гэрээний нөхцөлөөр тохирсон журмын дагуу явагддаг онцлогтой.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 2.2-т "Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд заасныаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө" гэж, мөн уг хуулийн 3.2-т "гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

---

[6] Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралт

худалдан авах ажиллагааны журмыг олон улсын гэрээнд өөрөөр заасан бол тухайн олон улсын гэрээнд заасан худалдан авах ажиллагааны журмыг хэрэглэж болох зохицуулалт, агуулгыг заасан" байдаг.

Олон улсын гэрээний нөхцөлөөр тохирсон худалдан авах ажиллагааны журмыг дагасан нөхцөлд урьдчилсан худалдан авах ажиллагааг хэрэглэж болохыг харуулж байгаа ба энэ нь олон улсын гэрээний тухай хуультай зөрчилдөх зөрчилдөөнийг үүсгэхгүй.

Иймд Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй болно.

## ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;

- Зардал, үр өгөөжийн харьцаа;

- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;

- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;

- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулснаар урьдчилсан, цахим, ногоон худалдан авах ажиллагааны шинэ зохицуулалтыг бий болгохоос гадна худалдан авах үйл ажиллагааны зарим зохицуулагдаагүй, ойлгомжгүй байгаа асуудлуудыг нэг мөр ойлгомжтой болгох асуудлыг шийдвэрлэж дэвшүүлсэн зорилгод хүрэх боломж өндөр байна.

Иймд дээрх асуудлуудыг хуулиар зохицуулах шаардлагатай тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

## ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Бусад орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлах хүрээнд урьдчилсан, цахим, ногоон худалдан авалтын чиглэлээр хийгдсэн судалгааны мэдээлэлд үндэслэн тодорхой нөхцөлийг тодруулах зорилгоор зарим улсын болон НҮБ-ыг сонголоо.

***Урьдчилсан худалдан авах ажиллагаа:***

- **Канад улс** нь Худалдан авах ажиллагааны хуулиар урьдчилсан худалдан авах ажиллагаатай холбогдсон харилцааг дараах байдлаар зохицуулсан.

- "Урьдчилсан гэрээлэх эрхийн мэдэгдэл" буюу "Advance Contract Award Notice"-нь 15 хоногийн дотор зарлах эрхийг өгдөг бөгөөд уг ханган нийлүүлэгч нарт хандсан мэдэгдэлд урьдчилсан тодорхойлогдсон гэрээлэгчидтэй бараа, үйлчилгээ болон барилгын ажлын худалдан авах ажиллагааны талаар гэрээ байгуулах зорилгоор явуулж байгаа гэдгийг илэрхийлдэг.

- "Гэрээг төлөвлөх болон урьдчилсан зөвшөөрөл" авах үйл ажиллагаа.

- Хэрэв худалдан авах ажиллагааны талаарх гарах үр дүн нь тодорхой бус, хангалттай мэдээлэл байхгүй бол "Гэрээг төлөвлөх болон урьдчилсан зөвшөөрөл" авах нөхцөлийг ашигладаггүй.

- "Гэрээг төлөвлөх болон урьдчилсан зөвшөөрөл" авах үйл ажиллагааг дуусгахаас өмнө худалдан авах ажиллагааны эрсдэлийн үнэлгээг заавал хийж мэдэгдсэн байх ёстой.

- **Нэгдсэн Үндэсний Байгууллагын** Олон улсын худалдааны эрх зүйн комиссын загвар хуулиар урьдчилсан худалдан авах ажиллагааг дараах байдлаар зохицуулсан.

- Ирээдүйн боломжит худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл

- Ирээдүйн жил, саруудын төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг Худалдан авах ажиллагааны тухайн байгууллага нь нийтэд зарлаж болно.

- Худалдан авах ажиллагааны тухайн байгууллага нь мөн ирээдүйн худалдан авах ажиллагааг урьдчилсан зарлан мэдээлж болно.

- Энэ заалтын хүрээнд ийнхүү зарлах нь тендерийн саналыг бий болгохгүй, тэрчлэн Худалдан авах ажиллагааны байгууллагад тендерийн саналыг бий болгох үүрэг хүлээлгэхгүй. Мөн ханган нийлүүлэгч болон гэрээлэгч нарт ямар нэг эрхийг бий болгохгүй.

- **Бүгд Найрамдах Индонез улсын** Ерөнхийлөгчийн Засгийн газрын бараа/үйлчилгээний худалдан авах ажиллагааны журам /2010 оны дугаар 54/-д урьдчилсан худалдан авах ажиллагааг дараах байдлаар зохицуулсан.

- 88-р заалтанд урьдчилгаа мөнгө зарцуулах зохицуулалтыг оруулсан ба уг хүрээнд урьдчилсан худалдан авах ажиллагааг явуулах боломжтой.

- 10-р бүлэгт олон улсын зээл, тусламжийн хүрээнд явуулах худалдан авах ажиллагааг зохицуулсан. Уг хүрээнд урьдчилсан худалдан авах ажиллагааг явуулах боломжтой.

- 4-р хэсэг 11-р заалтын 2 c, d хэсэгт: техник, туслалцааны зорилгоор урьдчилан худалдан авах ажиллагаа явуулж болох боломжийг зохицуулсан.

- 13, 22, 23-р зүйлүүдийн үйлчлэлийн хүрээнд урьдчилан худалдан авах ажиллагааг урьдчилан төлөвлөх, төсвийн хүрээнд шийдвэрлэх зохицуулалтуудыг тус тус тусгасан.

- **Филиппин улсын** 2016 оны Худалдан авах ажиллагааны хуулинд урьдчилсан худалдан авах ажиллагааг дараах байдлаар зохицуулсан.

Бүлэг 2: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

7. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон төсөв

7.2. Хэрэв худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө журмын дагуу батлагдаагүй бол худалдан авах ажиллагааг явуулахгүй. Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө нь жилийн төсөвтэй нийцсэн байх ба Худалдан авах ажиллагааны агентлагын дарга батална.

7.6. энэ хуулийн 7.2 дахь заалтыг үл харгалзан Худалдан авах ажиллагааны агентлаг худалдан авах ажиллагааг богино хугацаанд дараах нөхцөлтэйгөөр явуулж болно.

- ерөнхий нийцэл, төсвийн хуулийн дагуу авах зөвшөөрөл батлагдаагүй байх.

- худалдан авах ажиллагааг тухайн нөхцөл байдал, шаардлагаас хамаарч бараа, дэд бүтцийн төсөл эсхүл зөвлөхийн үйлчилгээг нэн дариу гүйцэтгэх шаардлагатай байх.

Мөн холбогдох төрийн байгууллага, агентлагууд жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг холбогдох агентлагын даргаар батлуулж, мөн "үндэсний зарцуулалтын хөтөлбөр"-ийг Ерөнхийлөгчөөс Парламент руу өргөн мэдүүлсний дараагаас тус тусын худалдан авах ажиллагааг эхлүүлэх бололцоотой байдаг. Энэ нь төсөл, хөтөлбөрийг амжилттай дуусгах, хэрэгжүүлэх зорилгоор төсвийн хууль батлагдсаны дараагаас худалдан авах ажиллагааг явуулах гэрээ байгуулах эрх олгох ажиллагаанд тус дөхөм болдог.

Дараах нөхцөл үйлчилдэг:

- Гэрээг хэрэгжүүлэх хугацаа 1 жилээс хэтрээгүй гэрээний хувьд, тухайн төсөв нь батлагдсан гэрээ нь худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөнд багтаж, Ерөнхийлөгчөөс Конгресс руу өргөн барьсан төсөвт багтсан байх,

- Төрийн өмчийн хяналттай компаниудын хувьд тухайн төсөв нь төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулагдсан байх,

- Орон нутгийн засаг захиргааны хувьд төсөв нь орон нутгийн Конгрес /Sanggunian/-д танилцуулагдсан байх,

- Олон жил хэрэгжих гэрээний хувьд, олон жилийн гэрээлэх ажлыг хянах зөвлөл/байгууллага эсхүл холбогдох баримт бичгээр шаардагдсан нөхцөлд тухайн зөвшөөрөгдөж төсөвлөгдсөн гэрээний дүн нь олон жилийн гэрээлэх ажлыг хянах зөвлөл/байгууллагын төсөв эсхүл холбогдох бичиг баримтанд тусгагдсан байна.

- Тухайн нөхцөл байдлаас хамаарч Төсвийн тухай хууль, байгууллагын төсөв, эсхүл холбогдох хууль/тогтоолоор төсөв батлагдаж зөвшөөрөгдөөгүй бол гэрээг байгуулж болохгүй.

***<u>Цахим худалдан авах ажиллагаа:</u>***

- **Бүгд Найрамдах Солонгос Улс** нь Худалдан авах ажиллагааны тухай хуулиар цахим худалдан авах ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг байна.

Цахим худалдан авах ажиллагааг 2000 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд БНСУ-ын Худалдан авах ажиллагааны газраас цахим худалдан авах ажиллагааны системийн хөгжүүлэлт, аюулгүй ажиллагааг хангаж ажилладаг. Тус улс нь зарлаж буй бүх тендерийг 100 хувь уг системээр дамжуулан зохион байгуулдаг. Мөн тус улс нь цахим худалдан авах ажиллагааны системд тоон гарын үсгийг ашигладаг бөгөөд бүх түвшний захиалагч байгууллагууд болон нийлүүлэгч байгууллагууд тоон гарын үсэг ашиглан системд ханддаг.

- **Гүрж улс нь** 2011 онд баталсан Худалдан авах ажиллагааны хуулиар цахим худалдан авах ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг байна.

2011 оноос эхлэн Цахим худалдан авах ажиллагааны систем http://procurement.gov.ge системийг хөгжүүлэн Засгийн газрын худалдан авах ажиллагааг 100 хувь уг системээр дамжуулан зохион байгуулдаг. Гүржийн Худалдан авах ажиллагааны газраас системийн хөгжүүлэлт, аюулгүй байдлыг хангаж ажилладаг.

- **Эстони улс** нь Худалдан авах ажиллагааны хуулиар цахим худалдан авах ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг байна.

Цахим засаглалыг хөгжүүлэх чиглэлээр нэлээдгүй амжилттай ажиллаж байгаа бөгөөд Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим системээр дамжуулан тендер шалгаруулалтыг 100 хувь зохион байгуулж байна. Тус системийн хувьд тоон гарын үсгийг ашигладаг бөгөөд Эстони улсын бус гадаадын аж ахуйн нэгжүүд тоон гарын үсэггүйгээр, тус улсын иргэн, аж ахуйн нэгжүүд тоон гарын үсгийг ашиглан тендер шалгаруулалтанд оролцдог. Естони улсын Худалдан авах ажиллагааны хууль нь 2007 онд батлагдсан бөгөөд 2010, 2011, 2013 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр цахим худалдан авах ажиллагаатай холбоотой зохицуулалтууд орсон байна.

***<u>Ногоон худалдан авах ажиллагаа:</u>***

- **Бүгд Найрамдах Солонгос Улс нь** 2005 онд баталсан Ногоон бүтээгдэхүүн худалдан авалтыг урамшуулах тухай хуулиар ногоон худалдан авах ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг.

Энэхүү хуулиар төрийн болон орон нутгийн байгууллага заавал ногоон бүтээгдэхүүн худалдан авах шаардлагатай ба тус хуулинд зааснаар зөвхөн дараах хэд хэдэн тохиолдолд ногоон худалдан авалт хийхгүй байж болохыг заасан байна:

1. Төлөвлөн авах гэж байгаа тухайн төрлийн бүтээгдэхүүнийн дотор ногоон бүтээгдэхүүн байдаггүй бол;

2. Тухайн ногоон бүтээгдэхүүн нь тогтвортой нийлүүлэлтгүй бол;

3. Газар нутгийн байршлаас шалтгаалан, эсвэл ногоон бүтээгдэхүүний чанар нь муугаас бүтээгдэхүүн худалдан авалтын зорилгодоо хүрэх боломжгүй бол;

4. Хэрэв олон нийтийн байгууллагын удирдлага нь "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмжийн тухай" хууль гэх мэт хуулийн дагуу хөнгөлөлттэй худалдан авах хүсэлд нийцүүлэн ногоон бүтээгдэхүүнээс өөр бүтээгдэхүүн авахаар төлөвсөн бол;

5. Хэрэв олон нийтийн байгууллагын удирдлага нь зайлшгүй шалтгаан, яаралтай эрэлтийн улмаас ногоон бүтээгдэхүүн худалдан авахад хүндрэл учирсан бол;

Энэхүү хуулинд зааснаар Байгаль орчны яамнаас Ногоон бүтээгдэхүүн худалдан авалтыг урамшуулах төлөвлөгөөг таван жил тутам гаргах ёстой ба бусад байгууллагуудад ногоон бүтээгдэхүүн худалдан авахад нь тус болохуйц ногоон бүтээгдэхүүний гарын авлага, мөн ногоон бүтээгдэхүүнийг цахим хэлбэрээр худалдан авах вэбсайт зэргийг гаргадаг байна. Уг хуулийн дагуу ногоон худалдан авалтыг хийсэн эсэхэд хяналт тавих үүднээс Ногоон бүтээгдэхүүн худалдан авалтын бүртгэлийг байгууллага бүр хийж, холбогдох дээд шатны удирдлага хянан шалгадаг байна. Ханган нийлүүлэлтийн ажилтнуудыг сургах, шинээр мэргэжилтэн бэлдэх, тэдний сургалтанд хамаарах бүх зардлыг улсаас хангах зэргийг тусгасан байдаг байна.

Мөн иргэдэд ногоон бүтээгдэхүүн хэрэглэхийг санал болгох үүднээс "Ногоон амьдралыг өргөжүүлье" уриан дор төрөл бүрийн сургалт, семинар хийх, хэвлэлээр сурталчлах асуудлыг гаргахыг хуульчлан оруулсан. "Ногоон бүтээгдэхүүн худалдан авахад дэмжлэг үзүүлэх төв", ногоон бүтээгдэхүүн худалдаалах албан ёсны "ногоон дэлгүүр" байгуулах эрх олгох, ногоон бизнес эрхлэгч, ногоон худалдан авагч аж ахуйн нэгж болон иргэдийг урамшуулах зэрэг олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

- **Япон улс нь** 2000 онд баталсан Ногоон худалдан авалтын хуулиар ногоон худалдан авах ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг.

Хуулийн зорилго нь төрийн байгууллагын ногоон худалдан авалтыг урамшуулах, тэднийг байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээллээр хангах, ингэснээр байгаль орчинд ээлтэй тогтвортой нийгмийг бий болгоход оршино.

**Хуулийн ерөнхий заалтууд нь:**

1. Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах "Үндсэн бодлого"-ыг жилд нэг удаа тус хуулийн 6 дугаар зүйлд зааснаар байгуулах ба энэхүү бодлогод Ногоон худалдан авалтыг урамшуулах чиглэл, худалдан авахаар тодорхойлсон бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан байна

2. Шүүх, яам, агентлагууд зэрэг байгууллага бүр тус тусын "Худалдан авалтын бодлого"-ыг энэ хуулийн 7 дугаар зүйлд зааснаар боловсруулан гаргаж энэхүү бодлого дээр үндэслэн бүтээгдэхүүн үйлчилгээгээ худалдан авна. Худалдан авалтын үр дүнг холбогдох удирдлагадаа мэдээлэх үүрэгтэй.

3. Орон нутгийн удирдах байгууллагууд мөн Ногоон худалдан авалтын бодлого боловсруулж үүн дээрээ тулгуурлан худалдан авалтын үйл ажиллагаагаа явуулдаг.

4. Бизнесийн байгууллага ба хувь хүмүүсийг заавал ногоон худалдан авалт хийхийг шаарддаггүй, харин тэднийг аль болох байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүнийг ухамсраараа худалдан авахыг хүсдэг байна.

5. Үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийхээ байгаль орчинтой холбоотой мэдээллээр хангах үүрэгтэй.

6. Эко тэмдэг олгодог байгууллагууд эко шошгоны хөтөлбөрөө илүү шинжлэх ухааны үндэслэлтэйгээр, олон улсын стандартад нийцүүлэн өргөжүүлэн ажиллах үүрэгтэй.

7. Засгийн газар нь үйлдвэрлэгч болон эко тэмдэг олгогч байгууллагаас гаргасан мэдээллийг зохицуулах, дүгнэлт хийх, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл хүргэх зохистой системээр хангах талаар анхаарч үзэх үүрэгтэй.

**"Худалдан авалтын үндсэн бодлого"-ын ерөнхий тоймд:**

- Байгаль орчинтой холбоотой шинж тэмдгийг илүү анхаарч, үнэ болон чанараас илүү чухалчлан үзнэ.

- Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн хүрээнд буюу үйлдвэрээс гараад хаягдал болох хүртэл байгаль орчинд нөлөөлөлж буй нөлөөллийг багасахад анхаарлаа хандуулна.

- Бүтээгдэхүүн нь хүлэмжийн хийн ялгарал бага гаргадаг байхад анхаарна.

- Худалдан авсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ урт хугацаанд, зөв ашиглах, зохистой хаях (ангилан хаях).

## ЗӨВЛӨМЖ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль нь улсын төсөв, орон нутгийн төсөв, сангийн хөрөнгө, гадаадын зээл, тусламж болон бусад эх үүсвэрээр ажил, бараа, үйлчилгээг төр худалдан авахад зохицуулагдах гол эрх зүйн акт юм.

- Олон улсын банк, санхүүгийн байгууллага болон бусад гадаад орнуудын зээл, тусламжийн хүрээнд явуулах төслийн худалдан авах ажиллагаанд урьдчилсан худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх механизмыг тогтоох;

- Цахим худалдан авах ажиллагааг бий болгох, хэрэгжүүлэх үндэслэл журмыг тогтоох; */Цахим худалдан авах ажиллагааны зардлын тооцоог Хавсралт 6-аас харна уу/*

- Байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний шалгуур үзүүлэлтийн худалдан авах ажиллагааны баримтлах аргачлалыг тогтоох;

- Худалдан авах үйл ажиллагааны зарим зохицуулагдаагүй, ойлгомжгүй байгаа асуудлуудыг нэг мөр ойлгомжтой болгох зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй бөгөөд дараах асуудлыг хуулийн төсөлд тусгах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Хуулийн агуулга, зорилго, нэгдмэл байдлыг хангах зорилгоор “өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ” гэх ойлголтыг зөвхөн тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах бараа, ажил, үйлчилгээ гэж тодорхойлох;

2. Олон улсын худалдан авах ажиллагааны шаардлага, зарчимд нийцүүлэн урьдчилсан худалдан авах ажиллагааны талаарх зохицуулалтыг нэмж тусгах;

3. Засгийн газрын худалдан авах ажиллагаа ил тод, шилэн байх зарчимд нийцүүлэн цахим худалдан авах ажиллагааны талаарх зохицуулалтыг нэмэх;

4. Засгийн газрын тогтвортой, байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх сөрөг нөлөө, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг дэмжсэн зохицуулалтыг нэмж тусгах;

5. Худалдан авах ажиллагааны улсын хяналтын байцаагчийн эрх зүйн байдлын талаарх зохицуулалтыг тусгах;

6. Хуулийг илүү боловсронгуй, ойлгомжтой, хэрэглэхэд хялбар болгох үүднээс хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах;

7. Худалдан авах ажиллагааны бодлого, зарчим болон Төсвийн тухай хуульд нийцүүлэн зарим хэсэг, заалтыг хүчингүй болгох;

8. Төсөл, арга хэмжээг шуурхай, үр нөлөөтэй зохион байгуулахын тулд зөвлөх сонгон шалгаруулах тендер 2 удаа амжилтгүй болсон тохиолдолд гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх боломжийг бүрдүүлэх, мөн орон нутагт хэрэгжих төсөл, арга хэмжээний хувьд тухайн шатны Засаг дарга захиалагч нь байх нэмэлт, өөрчлөлт оруулах;

9. Худалдан авах ажиллагааны практик шаардлагад үндэслэн зарим асуудлыг илүү тодорхой, ойлгомжтой болгох зорилгоор холбогдох нэр томъёог шинээр тодорхойлж, хуульд тусгагдсан зарим шаардлагагүй, ойлгомжгүй үг, найруулгыг хасах;

-------оОо-------

## Хавсралт 1. Урьдчилсан худалдан авах ажиллагааны процессийг харуулав:




[7] ЗГ эсхүл түүнээс эрх олгосон Яамнаас олон улсын банк, санхүүгийн байгууллагатай зээлийн гэрээнд гарын үсэг зурсны дараа УИХ-аар уг гэрээг соёрхон батлах хүртэлх дундаж хугацаа 3 сар байдаг. ЗГ, холбогдох байнгын Хороод болон зээл олгогч байгууллагаас хамаарч уг хугацаа 3 сараас дээш эсхүл доош байж болно.

**Тайлбар:**

Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр зохион байгуулсан төсөл арга хэмжээтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газраас 1991 оноос хойш хийгдсэн нийт зээлийн санхүүжилтийн гэрээг дүгнэн үзэхэд нийт зээл, тусламжийн хэлэлцээрийн **99 хувь нь** Засгийн газар болон УИХ-аас батлагдсан байна. Өөрөөр хэлбэл Засгийн газар оролцож байгуулсан гадаад зээл, тусламжийн гэрээ, хэлэлцээр батлагдахгүй байх магадлал **1-2 хувьтай** байна. Энэ нь урьдчилсан худалдан авах ажиллагааны үр дүнд эрсдэл гарах магадлал бага гэдгийг батлан харуулж байгаа.[8]

**Дээрх цаг хугацааны хүснэгт дээр үндэслэн жишээ дурдвал:**

1. 300 сая ам долларын зээлээр хэрэгжих төсөл 5 жил хэрэгжинэ гэж тооцоольё. Уг зээл жилийн 2 хувийн хүүтэй, 30 жилд эргэн төлөгдөн гэж үзье. Зээлийн хүүд ЗГ жилд 6 сая ам доллар төлөх ёстой. Мөн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж төлөх ёстой энэ нь дунджаар 0.15 хувь буюу 450,000 ам доллар. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн нийт зардалд жилд 300-400 мянган ам доллар зарцуулна. Жилд гарах хүү, төлбөрийн бүх зардлыг тооцвол 7,000,000 ам доллар орчим байна. */Зарим тохиолдолд гэрээн дээр үндсэн хүүнээс чөлөөлөх хугацаа дунджаар 5 жил байдаг/*

2. В хугацаа буюу зээл хүчин төгөлдөр болсны дараагаас эхлэн төсөл арга хэмжээний төлөвлөгөө, төслийн нэгжийн ажилтнуудыг сонгон шалгаруулах, тендерийн баримт бичиг боловсруулах, ажлын даалгавар бэлтгэх, холбогдох арга хэмжээний ТЭЗҮ хийх гэх мэт арга хэмжээ эхэлснээр Төсөл хэрэгжих 5 жилийн эхний 1-2 жилийг үр ашиггүй зарцуулах тохиолдол үүсдэг. Энэхүү хугацаа алдсан 1-2 жилд ЗГ гэрээний үүргийн дагуу зээлийн хүү, төлбөрөө төлдөг. Өөрөөр хэлбэл ЗГ зээлийг ашиглаагүйн төлөө төлж буй үргүй зардал гэж үзэж болох юм. Тухайлбал төсөл хэрэгжих 5 жилийн хугацаа 6-8 жил болсноор, уг сунгагдсан нэмэлт 1-3 жилийн хугацаанд гарах үр ашиггүй хүү, зардал, төлбөрийн хэмжээ ойролцоогоор 7,000,000-22,000,000 ам доллар байна.

3. Хэрэв энэхүү хугацаа алдалтыг А буюу зээл, төсөл арга хэмжээг хэлэлцэн шийдвэрлэх үеэс эсхүл Б хугацаа буюу зээл, төслийг Засгийн газар болон санхүүжүүлэгч байгууллагаас баталсан өдрөөс эхэлж эхлүүлсэн тохиолдолд хугацаа алдалтыг багасгах бүрэн боломжтой. Худалдан авах ажиллагааг урьдчилан эхлүүлснээр 3 сараас 1 жилийг хожно, зардал багасна. Засгийн газар бодит бүтээн байгуулалт, хөгжлийн хөтөлбөрт хүү, төлбөр төлөх болно. Төсөл хөтөлбөрөөс улбаатай бусад арга хэмжээнүүд цаг хугацаа алдалгүй эдийн засгийг эргэлтэнд орох өндөр ач холбогдолтой.

**Яамдын зээлээр хэрэгжсэн төслийн хугацаа алдсан жишээг дурдвал:**

---

[8] Сангийн яамны Өрийн удирдлага, Хөгжлийн санхүүжилтийн газраас гаргасан судалгаа.

1. Зам тээврийн яам: Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр Төсөл1. 2847-MON:
**Нөхцөл:** Зээлийн санхүүжилт 28,381,000.00 сая ам доллар /зээлжих тусгай эрх/, хэрэгжих хугацаа 2012-2016.12.31, эргэн төлөх хугацаа 22 жил. Төсөл хэрэгжиж эхлэх хугацаанаасаа удааширсан бөгөөд үр дүнд "Бага Улаан даваа-Манхан чиглэлийн 103.3 км" хатуу хучилттай авто замын ажил төлөвлөгдсөн хугацаандаа ажилд ороогүй.

**Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа**: 8 жил

**Хүү, бусад шимтгэлийн хэмжээ 1-1.5 хувь**: 2020 оноос эхлэн 6 сар тутамд 591,271 ам доллар төлнө.

**2017 оны 7-р сарын байдлаар төлсөн төлбөр**: Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал нийт 561,000 ам доллар.

**Гүйцэтгэл**: Төлөвлөсөн хугацаандаа ороогүй. 2 жил хугацаа алдсан.

**Хугацаа алдсанаас хамааралтай орон нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө**: Тооцоолох боломжгүй. Сөрөг үр дагавартай.

**Дүгнэлт:** Энэхүү төсөл нь анхны 37,600,000 ам долларын тусламжийн төслөөр хийгдэх ажил дээр нэмэлт зардал, нэмэлт ажил хийхтэй холбогдуулан нэмж зээлсэн төслийн зээл юм.

Урьдчилсан худалдан авах ажиллагааг хэрэглэсэн тохиолдолд төсөл амжилттай явагдах үндэслэлтэй байсан бөгөөд нэмэлт зээлийг 28 сая ам доллараас харьцангуй бага хэмжээнд авах боломжтой байсан байна.

2. Зам тээврийн яам: Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр Төсөл-2. 3129 МОН:
**Нөхцөл:** АХБ-ны зээл, 125 сая ам доллар /зээлийн санхүүжилт/, эргэн төлөх 15 жил, хугацаа 2014-2018.12.31, Төслийн хүрээнд "Ховд-Өлгий-Улаанбайшинт" чиглэлийн 189.7 км авто замын барилга, угсралтын ажил хийгдэх ч ажил удааширсан.

**Төслийн ажлын хугацаа алдалт**: Хугацаандаа амжаагүй.

**Үндсэн хүү төлбөрөөс чөлөөлх хугацаа**: 00

**Хүү, бусад шимтгэлийн хэмжээ**: 3.3 хувь

**2014-2017 онд төлөх төлбөр**: 750,000 ам доллар.*албан бусаар тооцоолов.* /зээл ашиглагдаагүйд төлж буй хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж/

**Төслийн нэгжийн зардал**: 1,400,000 ам доллар

**Үндсэн хүү төлөх хугацаа**: 2019.10.15-аас эхлэн 6 сар тутамд 3,333,333 ам доллар эргэн төлнө.

**Гүйцэтгэл:** 2 жилийн хугацаа алдсан, төлөвлөгдсөн хугацаандаа амжаагүй.

**Хугацаа алдсанаас хамааралтай орон нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө:** Тооцоолох боломжгүй. Сөрөг үр дагавартай.

**Дүгнэлт:** Урьдчилсан худалдан авах ажиллагааг хэрэглэсэн тохиолдолд төсөл амжилттай явагдах үндэслэлтэй байсан. Мөн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж болон төслийн захиргааны нэмэлт зардлуудаас урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой байсан байна.

3. Эрчим хүчний яам: Төслийн нэр BMZ-82865625. Дарханы ДЦС-н ТӨХК-н турбины шинэчлэл төсөл:

**Нөхцөл:** 10,5 сая еврогийн зээл, Засгийн газраас 10.4 тэрбум төгрөгийн санхүүжилт, 2011-2017 он. Уг төсөл ОХУ-н гүйцэтгэгчтэй холбоотой асуудлаар удааширсан гэх. 2016 оны 4-р сард нэмэлт 4.5 сая еврогийн нэмэлт зээлийг шийдсэн. Дахин нэмэлт 5 сая еврогийн асуудал Засгийн газар, Байнгын хороодоор хэлэлцэгдсэн. Одоо УИХ-н чуулганаар хэлэлцэгдэх төлөвлөгөөнд орсон.

**Хугацаа алдалт**: 3 жил

**Гүйцэтгэл**: 55 хувь гэх

**Үндсэн хүү, төлбөрт төлсөн дүн**: 2018 оноос эхэлж төлнө.

**Нэмэлт зээл авсан байдал**: 4.5 сая евро /нэмэлтээр 5 сая евро дахин авах/

**Хугацаа алдсанаас хамааралтай орон нутгийн нийгэм, эдийн засаг, засгийн газарт үзүүлэх нөлөө**: Төсөл арга хэмжээ удааширснаас засгийн газар үндсэн зээл болох 10.5 сая евро дээр нэмэлтээр 4.5 сая евро нэмж зээлсэн. Дахин 5 сая евро нэмж зээлнэ. Орон нутагт үзүүлэх сөрөг нөлөөллийг тооцоолох боломжгүй. Сөрөг үр дагавартай.

**Дүгнэлт:** Төсөл арга хэмжээний тендер шалгаруулалт, гүйцэтгэгчийн үүргийн биелэлттэй холбоотойгоор төсөл удааширч засгийн газарт зээл дахин авах асуудал үүссэн байна. Тендер шалгаруулалтыг амжилттай явуулж, урьдчилсан худалдан авах ажиллагааг хэрэглэсэн тохиолдолд төсөл амжилттай явагдах үндэслэлтэй байсан. Өөрөөр хэлбэл нэмэлт 4.5 сая евро болон дахин 5 сая еврог зээлэх шаардлагагүй байх боломжтой байсан байна.

## Хавсралт 2. Олон улсын банк, санхүүгийн байгууллагын урьдчилсан худалдан авах ажиллагааны зарчим:

| # | Санхүүгийн байгууллага | Урьдчилсан худалдан авах ажиллагааны талаарх зарчим | Үндсэн шаардлага болон нөхцөл | Урьдчилсан худалдан авах ажиллагааны талаарх шийдвэр болон цаг хугацаа | Төсөв/зардлын талаарх практик[9] | Адил болон ялгаатай байдал |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Дэлхийн Банк | Зээлдэгчийн зүгээс зээлийн гэрээнд гарын үсэг зурахаас өмнө худалдан авах ажиллагааг явуулах хүсэлт гаргаж болно. Зээлдэгчээс Худалдан авах ажиллагааны гэрээнд орсон нөхцөлд энэ нь зээлдэгчийн өөрийн үүрэх эрсдэл бөгөөд ДБ-аас үйл ажиллагаа, баримт бичиг, гэрээ байгуулах санал зэрэгт зэрэгт өгсөн зөвшөөрөл нь ДБ-г уг төслийг санхүүжүүлнэ гэсэн амлалт биш юм.[10] | Эцсийн батлагдах гэрээний шаардлагыг хангахын тулд ДБ-ны Худалдан авах ажиллагааны журмыг баримтлах ёстой бөгөөд ингэхдээ зар сурталчилгаан дээр мөн адил баримтална. | Тодорхой цаг хугацаа заагаагүй | #Худалдан авах ажиллагааны бэлтгэл ажилтай холбоотойгоор зээлдэгчид зардлын асуудал гарч болно. #Анхны зардал зээлдэгчээс өөрөөс нь гарах бөгөөд энэ нь зээлдэгчийн эрсдэл юм. | Зарчим адилхан |
| 2 | АХБ | Зээлдэгчийн зүгээс зээлийн гэрээнд гарын үсэг зурахаас өмнө худалдан авах ажиллагааг явуулах боломжийг АХБ-наас дэмждэг.Зээлдэгчээс УХудалдан авах ажиллагааны гэрээнд орсон нөхцөлд энэ нь зээлдэгчийн өөрийн үүрэх эрсдэл бөгөөд АХБ-аас үйл ажиллагаа, баримт бичиг, гэрээ байгуулах санал зэрэгт зэрэгт өгсөн зөвшөөрөл нь АХБ-аас уг төслийг санхүүжүүлнэ гэсэн амлалт биш юм.[11] | Эцсийн батлагдах гэрээний шаардлагыг хангахын тулд АХБ-ны Худалдан авах ажиллагааны журмыг баримтлах ёстой бөгөөд ингэхдээ зар сурталчилгаан дээр мөн адил баримтална. Түүнчлэн АХБ нь хэрэгжилтийн үйл ажиллагааг хянана. | Тодорхой цаг хугацаа заагаагүй | #Анхны зардал зээлдэгчээс өөрөөс гарах бөгөөд энэ нь зээлдэгчийн эрсдэл юм. | Зарчим адилхан |
| 3 | ЁСБХБ | Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой ХАА-д урьдчилсан | УХудалдан авах ажиллагааны зарчимаар урьдчилсан худалдан авах ажиллагаа | Тодорхой цаг хугацаа заагаагүй. | # Худалдан авах ажиллагааны бэлтгэл ажилтай холбоотойгоор | Зарчим адилхан |

[9]УХудалдан авах ажиллагааны зарчим дээр үндэслэсэн Зөвлөхийн өөрийн тайлбар. Ерөнхийдөө энэ талаар зээлдэгчээс эсхүл санхүүжүүлэгч банкнаас зардал, төсөвийг санхүүжүүлэх талаар тэдгээрийн холбогдох Худалдан авах ажиллагааны баримт бичгүүдэд дурдагдаагүй, зохицуулагдаагүй болохыг тэмдэглэв.

[10] Дэлхийн банкны Худалдан авах ажиллагааны журам (2016 оны 7-р сар)

[11] АХБ-ны Худалдан авах ажиллагааны журам (2015 оны 4-р сар)

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | худалдан авалтыг явуулахыг ЁСБХБ-ны зүгээс дэмждэг.[12] | явуулах зарлал, мэдэгдлийг онцлон дурдсан байдаг. | | зээлдэгчид зардлын асуудал гарч болно. #Анхны зардал зээлдэгчээс өөрөөс гарах бөгөөд энэ нь зээлдэгчийн эрсдэл юм | |
| 4 | **Америкийн Хөгжлийн Банк** | Зээлдэгчийн зүгээс зээлийн гэрээнд гарын үсэг зурахаас өмнө худалдан авах ажиллагааг явуулах хүсэлт гаргаж болно.Зээлдэгчээс УХудалдан авах ажиллагааны гэрээнд орсон нөхцөлд энэ нь зээлдэгчийн өөрийн үүрэх эрсдэл бөгөөд банкнаас үйл ажиллагаа, баримт бичиг, гэрээ байгуулах санал зэрэгт зэрэгт өгсөн зөвшөөрөл нь уг төслийг санхүүжүүлнэ гэсэн амлалт биш юм.[13] | #Эцсийн батлагдах гэрээний шаардлагыг хангахын тулд банкны Худалдан авах ажиллагааны журмыг баримтлах ёстой бөгөөд ингэхдээ зар сурталчилгаан дээр мөн адил баримтална. Тэрчлэн банк нь хэрэгжилтийн үйл ажиллагааг хянана.<br><br>#Урьдчилсан худалдан авах ажиллагаанд урьдчилсан хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанууд, үйл ажиллагааны бэлтгэл ажил, тоног төхөөрөмжийг худалдан авах захиалга, болон гэнэтийн яаралтай үеийн нөхцөлүүдийг багтаасан. | Тодорхой цаг хугацаа заагаагүй. | # Худалдан авах ажиллагааны бэлтгэл ажилтай холбоотойгоор зээлдэгчид зардлын асуудал гарч болно. #Анхны зардал зээлдэгчээс өөрөөс гарах бөгөөд энэ нь зээлдэгчийн эрсдэл юм | Зарчим адилхан |
| 5 | **Африкийн Хөгжлийн Банк** | Зээлдэгчийн зүгээс зээлийн гэрээнд гарын үсэг зурахаас өмнө худалдан авах ажиллагаа явуулах хүсэлт гаргаж болно.Зээлдэгчээс УХудалдан авах ажиллагааны гэрээнд орсон нөхцөлд энэ нь зээлдэгчийн өөрийн үүрэх эрсдэл бөгөөд банкны зүгээс үйл ажиллагаа, баримт бичиг, гэрээ байгуулах санал зэрэгт зэрэгт өгсөн | #Эцсийн батлагдах гэрээний шаардлагыг хангахын тулд банкны Худалдан авах ажиллагааны журмыг баримтлах ёстой бөгөөд ингэхдээ зар сурталчилгаан дээр мөн адил баримтална. Тэрчлэн банк нь хэрэгжилтийн үйл ажиллагаг хянана. | Урьдчилсан хөрөнгө оруулалтын судалгаанаас бусад урьдчилсан худалдан авалт нь зөвхөн төслийн бэлтгэл | # Худалдан авах ажиллагааны бэлтгэл ажилтай холбоотойгоор зээлдэгчид зардлын асуудал гарч болно. #Анхны зардал зээлдэгчээс өөрөөс гарах бөгөөд энэ нь зээлдэгчийн эрсдэл юм. | #Зарчим адилхан. #Зарлал дээр зээлдэгч нь банкнаас зээл авахаар хүсэлт гаргасан гэдгийг заавал мэдэгдэнэ. Гэрээ зурагдахтай холбоотой гарах |

[12]ЁСБХБ-ны Худалдан авах ажиллагааны Бодлого.

[13]Америк Хоорондын Хөгжлийн Банкны Худалдан авах ажиллагааны бодлого, журам (2011 оны 3-р сар)

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | зөвшөөрөл нь уг төслийг санхүүжүүлнэ гэсэн амлалт биш юм.[14] | | хангагдаж, үнэлгээ дууссаны дараагаар авч хэлэлцэгдэх ёстой. | | ямар ч зардал нь санхүүжүүлэгчээс заавал зөвшөөрөл авсан байх ёстой. |
| 6 | **Мянганы Сорилтын Корпораци** | Тухайн төслийг хэрэгжүүлэх байгууллага нь МСК-н зөвшөөрөлтэйгээр тухайн төслийг санхүүжүүлэх гэрээ зурагдахаас өмнө тодорхой худалдан авах ажиллагааг явуулах хүсэлт гаргаж болно. Зээлдэгчээс УХудалдан авах ажиллагааны гэрээнд орсон нөхцөлд энэ нь зээлдэгчийн өөрийн үүрэх эрсдэл бөгөөд банкнаас үйл ажиллагаа, баримт бичиг, гэрээ байгуулах санал зэрэгт зэрэгт өгсөн зөвшөөрөл нь уг төслийг санхүүжүүлнэ гэсэн амлалт биш юм.[15] | #ХАА нь (үүнд зарлан мэдээлэх багтана) МСК-н Худалдан авах ажиллагааны журмын дагуу явагдах бөгөөд МСК-иас зээлдэгчээс явуулах үйл ажиллагааг хянана.<br>#Ямар ч нөхцөлд хэрэв Төсөл хэрэгжүүлэгч нь МСК-иас зөвшөөрөл аваагүй бөгөөд санхүүжилтийн гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнөх гарын үсэг зурсан гэрээтэй холбоотой зардалд нөхөн төлбөр хийхгүй. | Тодорхой цаг хугацаа заагаагүй. | #Худалдан авах ажиллагааны бэлтгэл ажилтай холбоотойгоор зээлдэгчид зардлын асуудал гарч болно.<br>#Анхны зардал зээлдэгчээс өөрөөс гарах бөгөөд энэ нь зээлдэгчийн эрсдэл юм. | Адилхан зарчим |
| 7 | **НҮБ** | Төсөв батлагдахаас өмнө ямар ч санхүүгийн үүрэг, амлалт үүсэхгүй. Хэрэв урьдчилсан худалдан авалт нь онцгой тохиолдолд шаардагдвал энэ талаар ханган нийлүүлэгчдэд энэ нь шаардлагатай байж болох таамаглал юм гэдгийг заавал мэдэгдсэн байхыг шаарддаг.[16] | # Урьдчилсан худалдан авалт нь зөвхөн бүрэн хэмжээний холбогдох зөвшөөрлийг авсан нөхцөлд л явагдана.<br>#Урьдчилсан худалдан авах ажиллагааны талаарх санал, шийдвэр зэрэгт тодорхой заагдсан удирдлагуудын зөвшөөрлийг авсан байна. | Тодорхой цаг хугацаа заагаагүй. | #Худалдан авах ажиллагааны бэлтгэл ажилтай холбоотойгоор зээлдэгчид зардлын асуудал гарч болно.<br>#Анхны зардал зээлдэгчээс өөрөөс гарах бөгөөд энэ нь зээлдэгчийн эрсдэл юм. | Адилхан зарчим |

**Дүгнэлт:**

[14]Африкийн Хөгжлийн Банкны Худалдан авах ажиллагааны бодлого, журам (2008 оны 5-р сар, 2012 оны 7-р сард шинэчлэгдсэн)
[15] Мянганы Сорилтын Корпорацийн Худалдан авах ажиллагааны журам (2015 оны 8-р сарын 15) (https://www.mcc.gov/resources/doc/program-procurement-guidelines)
[16] НҮБ-н Худалдан авах ажиллагааны гарын авлага (2006 оны 11-р сар, 2012 оны 9-р сард шинэчлэгдсэн)

Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын урьдчилсан худалдан авах ажиллагааны зарчмыг дүгнэхэд:

- Зээлдэгч нь өөрөө бүхий л эрсдэлийг хүлээх ёстой.
- Хэрэгжих төслийн хүрээнд талуудаас гэрээний яриа хэлэлцээг эхлүүлсэн байх ёстой.
- Урьдчилсан худалдах авах ажиллагааны талаарх үндэслэл, шаардлагыг бэлтгэсэн байх.
- Холбогдох санхүүжүүлэгч байгууллагуудын гаргасан худалдан авах ажиллагааны журмын дагуу явагдсан байх.
- Хэрэв боломцоотой бол ямар нэг зардал үүснэ, гаргана гэсэн үүрэг амлалтыг бий болгохгүй байх.
- Урьдчилсан худалдан авах ажиллагааны талаарх аливаа зарлал, мэдээлэл нь *"энэхүү худалдан авах ажиллагааны зарлал нь урьдчилсан худалдан авах ажиллагаа гэдэг"*-ийг заавал тайлбарлаж, мөн энэ нь санхүүжүүлэгчээс зөвшөөрөгддөг гэдгийг заавал мэдэгдсэн байхыг шаарддаг.
- Хэрэв гэрээ зурагдаж зээлдэгчээс тодорхой зардал гаргасан бөгөөд тухайн гэрээг санхүүжүүлэгчээс зөвшөөрч нөхөн олговор олгосон нөхцөлд үүнийг нөхөн санхүүжүүлэх гэж нэрлэдэг.

Дүгнэхэд Монгол Улсын хувьд урьдчилсан худалдан авах ажиллагааны журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталж гаргах хувилбар зөв болох нь харагдаж байна. Холбогдох зааврыг нарийвчлан гарган мөрдүүлснээр дээр дурдсан зарчмыг нэг мөр хангаж ажиллуулах, аливаа эрсдэл гаргахгүй байх, оновчтой удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авах нөхцөл боломцоо бүрдэх юм.

## Хавсралт 3. Урьдчилсан худалдан авах ажиллагааны зардлын талаарх хүснэгт, дүгнэлт

| Хуулийн төслийн чиглэл | Байгууллагын гүйцэтгэх үүрэг | Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөц | Урьдчилсан тооцоолсон зардал:<br>*-Хүний нөөц*<br>*-Материаллаг зардал*<br>*-Бусад зардал* | Нийт Зардал | Дүгнэлт, Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| Урьдчилсан худалдан авах ажиллагаа | -Сангийн яам удирдан зохион байгуулах үүрэг гүйцэтгэнэ.<br>-Төсөл хэрэгжүүлэх зээлийн гэрээ батлагдаж хүчин төгөлдөр болохоос өмнө төслийн хэрэгжилтийг урьдчилан хангуулах арга хэмжээг авна. | Төсөл, хөтөлбөрийн бэлтгэл үйл ажиллагааг хангах зээлээр хэрэгжих төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг Сангийн яам удирдан зохион байгуулна. | Төсөвт урьдчилан тооцоологдох зардал үгүй. | Одоо байгаа батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд шийдэгдэнэ. | Төсөвт зардал гарахгүй.<br>Төсөв эрсдэл, сөрөг нөлөө байхгүй.<br>Дотоод зохион байгуулалт, төслийн зохион байгуулалт санхүүжилтээр шийдэгдэнэ. |
| Дүгнэлт: | Урьдчилсан худалдан авах ажиллагааны онцлог нь зардал гарахгүй дараах шалтгаантай:<br>1. Урьдчилсан худалдан авах ажиллагааг зөвхөн гадаад, зээл тусламжийн төсөл, хөтөлбөрийн хүрээнд явуулна. Энэ нь уг зээл, тусламжийн хэлэлцээрийн үндсэн нөхцөлд урьдчилсан худалдан авах ажиллагааг явуулж болох болон түүнтэй холбоотой зардлыг багтаасан байдаг. Урьдчилсан худалдан ажиллагааг эхлүүлж тодорхой зардал гарсан нөхцөлд энэ нь эргээд тухайн батлагдсан төсөл, хөтөлбөрөөс эргэн төлөгдөх замаар нөхөн санхүүждэг ба энэ нь улсын төсвөөс гарах зардалтай хамааралгүй байдаг.<br>2. Урьдчилсан худалдан авах ажиллагааны явцад гол төлөв төсөл, хөтөлбөрийн бэлтгэл ажил, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, холбогдох тендерийн баримт бичиг зэргийг боловсруулах ажлыг эхлүүлэх шаардлагатай байдаг ба эдгээр ажлыг тухайн хариуцаж байгаа чиглэлийн төрийн байгууллагууд гүйцэтгэх юм. Уг ажлыг гүйцэтгэхэд нэмэлт зардал гарахгүй. Харин сонгон шалгарсан ажилтнуудыг ажилд авах, цалинг олгох тохиолдолд төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээс нөхөн санхүүжүүлэх юм. | | | | |

| | |
|---|---|
| | 3. Урьдчилсан худалдан авах ажиллагааны явцад мөн тендерт оролцогчтой гэрээ байгуулахгүй байх онцлогтой бөгөөд урьдчилсан худалдан авах ажиллагаа гэдгийг тайлбарласан санамж бичиг үйлддэг. Зөвхөн зээл, тусламжийн гэрээ хүчин төгөлдөр болж үйлчилсэн нөхцөлд гэрээ байгуулах нөхцөл үүсдэг ба ингэснээр хэрэв зардал гарсан нөхцөлд нөхөн санхүүжүүлэх асуудал яригддаг.<br><br>Дүгнэхэд урьдчилсан худалдан авах ажиллагааны явцад улсын төсөвт гарах, үүсэх зардлын тооцоо байхгүй. Харин онцгой нөхцөлд зардал үүссэн нөхцөлд энэ нь төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээс эргэн төлөгдөж нөхөн санхүүжилтийн хэлбэрээр хийгддэг байна. Тендерт оролцогчтой холбоотой зардал, тооцооны эрсдэл, сөрөг нөлөөлөл үгүй байна. |

**Хавсралт 4. Хүний эрх, эдийн засаг, нийгэм болон байгаль орчинд үзүүлэх нөлөө.**

1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө.

| **Үзүүлэх үр нөлөө:** | **Холбогдох асуултууд** | **Хариулт** | | **Тайлбар** | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх | **1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх** | | | **Урьдчилсан худалдан авах ажиллагаа** | **Цахим худалдан авах ажиллагаа** | **Ногоон худалдан авах ажиллагаа** |
| | Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх | **Тийм** | Үгүй | Худалдан авах үйл ажиллагаа нь ил тод, эрх тэгш, өрсөлдөх боломжтой, үр ашигтай, хэмнэлт, хариуцлагатай байхад чиглэгдсэн. | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | Тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх | Тийм | Үгүй | Хамааралгүй. | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | **1.2. Оролцоог хангах** | | | | | |
| | Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг | **Тийм** | Үгүй | Худалдан авах ажиллагаанд хүн бүр тэгш оролцох, | Эрх, тэгш, шударга | Хамааралгүй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх | | | өрсөлдөх эрхтэй бөгөөд аль нэг этгээдэд хуульд тусгайлан заагаагүй л бол давуу байдал бий болгохыг хориглодог. | нөхцөлийг бэхжүүлж байгаа. | |
| | Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Хөхиүлэн дэмжиж байгаа. | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | **1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага** | | | | | |
| | Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх | **Тийм** | Үгүй | Хуулиар худалдан авах үйл ажиллагаа нь ил тод, эрх тэгш, өрсөлдөх боломжтой, үр ашигтай, хэмнэлт, хариуцлагатай байхад чиглэгдсэн. | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх | **Тийм** | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх | Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 3. Эрх агуулагч | Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх | **Тийм** | Үгүй | Ямар нөхцөлд хэрхэн эрх үүсэх эсэх талаар төсөлд тодорхой чиглүүлсэн. | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх | Тийм | **Үгүй** | Ийм нөхцөл, харилцаа үүсэхгүй. | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх | Тийм | Үгүй | Ийм нөхцөл, харилцаа үүсэхгүй. | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/ | | | | | |
| 4. Үүрэг хүлээгч | Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх | **Тийм** | Үгүй | Урьдчилсан худалдан авах ажиллагаанд шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнуудыг тодорхойлж, эрх хэмжээг зааглан тодорхойлно. | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх | Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх | **Тийм** | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх | **Тийм** | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

| **Үзүүлэх үр нөлөө** | **Холбогдох асуулт** | **Хариулт** | **Тайлбар** | | |
|---|---|---|---|---|---|
| | | | **Урьдчилсан худалдан авах ажиллагаа** | **Цахим Худалдан авах ажиллагаа** | **Ногоон худалдан авах ажиллагаа** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар | 1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан) | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх | **Тийм** | | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Дотоодын худалдан авах ажиллагааны өрсөлдөөн, хүртээмжийг бэхжүүлж, нэмэгдүүлнэ. | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал | 2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Тухайн зээлийн хэлэлцээрт заасан нөхцөлд хязгаарлагдмал өрсөлдөөн бий болж болно. Сөрөг үр дагавар үгүй. | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн | 3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| болон захиргааны зардал | 3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал | 4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 5.Өмчлөх эрх | 5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 6.Инноваци болон судалгаа шинжилгээ | 6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв | 7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 8.Тодорхой бүс нутаг, салбарууд | 8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх | | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 9.Төрийн захиргааны байгууллага | 9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх | Тийм | **Үгүй** | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
